



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 16-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2026 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр, Пүрэв гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	3-8
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	9-50
<hr/>	
<b>1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2026.03.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/</b>	12-14
<b>2.Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 3 гишүүн 2025.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	14-34
<b>3.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>	34-49
<b>4.Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл</b>	49-50

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
4 дүгээр сарын 16-ны өдөр /Пүрэв гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 84 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 01 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.<sup>1</sup>

Томилолттой: Х.Баттулга, Д.Ганмаа, Г.Дамдинням, Т.Доржханд, Х.Жангабыл, Ж.Золжаргал, Г.Лувсанжамц, Б.Мөнхсоёл, О.Номинчимэг, Л.Соронзонболд, Д.Үүрийнтуяа;

Чөлөөтэй: О.Алтангэрэл;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, Л.Мөнхбаатар, С.Эрдэнэбат;

Тасалсан: Д.Батбаяр, Ц.Туваан, Г.Уянгахишиг;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-13 минут, С.Амарсайхан-2 цаг 17 минут, Ч.Анар-22 минут, М.Бадамсүрэн-12 минут, Д.Батлут-02 минут, Ж.Батсуурь-04 минут, Ж.Баясгалан-01 минут, Г.Ганбаатар-34 минут, Д.Ганбат-11 минут, Б.Жавхлан-04 минут, Д.Жаргалсайхан-2 цаг 11 минут, Ц.Мөнхбат-07 минут, П.Мөнхтулга-2 цаг 04 минут, З.Мэндсайхан-06 минут, Л.Оюун-Эрдэнэ-11 минут, Б.Пунсалмаа-28 минут, Ц.Сандаг-Очир-06 минут, Р.Сэддорж-07 минут, Г.Тэмүүлэн-04 минут, Ч.Ундррам-07 минут, Ж.Энхбаяр-08 минут, Р.Эрдэнэбүрэн-03 минут.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Д.Пүрэвдаваа нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

**Өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар мэдээлэх**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 8 гишүүн 2026 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороонд хуваарилсныг танилцуулав.

<sup>1</sup> Хуралдаан даргалагч ирцийг танилцуулах үед 2 гишүүн ирцэд нэмэгдсэн.

### **Хуулийн төсөл татан авах талаар танилцуулах**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслүүдийг татан авах тухай Засгийн газраас 2026 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр ирүүлсэн албан бичгийг танилцуулж, хуулийн төслүүдийг татан авсанд тооцов.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т заасны дагуу хууль санаачлагч төслөө татан авсанд тооцлоо./10:13/*

**Нэг.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2026.03.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, мөн газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хэвлэлийн төлөөлөгч, хэвлэл мэдээллийн албаны дарга Ц.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх тухай асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэж үг хэлэв./10:15/

*Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлэв.*

**С.Бямбацогт:** 1.Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57  
Татгалзсан: 44

Бүгд: 101

56.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

**С.Бямбацогт:** 2.Байнгын хорооны саналаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 45

Бүгд: 101

55.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

**С.Бямбацогт:** 3.Байнгын хорооны саналаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 46

Бүгд: 101

54.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

**С.Бямбацогт:** 4.Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 46

Бүгд: 101

54.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 10 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 3 гишүүн 2025.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Шинжлэх ухааны академийн Дэд ерөнхийлөгч Б.Авид, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны дарга Б.Бат-Эрдэнэ, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Туул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх А.Болортуяа, референт Б.Энхмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, М.Ганхүлэг, С.Эрдэнэболд, О.Саранчулуун, Д.Рэгдэл нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Туул нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн үг хэлэв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /11:23/*

***Гурав. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, мөн газрын ахлах референт Д.Нямдэлгэр, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, мөн газрын Геодези, зураг зүйн хэлтсийн дарга Д.Мөнхцэцэг, Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга Б.Оюунхорол, Шинжлэх ухааны академийн Нийгмийн шинжлэх ухаан хариуцсан Дэд ерөнхийлөгч Ц.Цэрэндорж, мөн академийн Газар зүй, гео-экологийн хүрээлэнгийн захирал А.Дашцэрэн, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга, доктор Н.Нарангэрэл, мөн зөвлөлийн гишүүн, доктор О.Шинэбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Энхгэрэл нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, О.Саранчулуун, Ө.Шижир нарын тавьсан асуултад Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга, доктор Н.Нарангэрэл нар хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.4-т хуралдааны дэг зөрчсөн гишүүнд хүлээлгэх хариуцлагын талаар заасныг Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарад уншиж танилцуулав./11:51/*

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, О.Саранчулуун нар үг хэлэв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /12:15/*

### ***Дөрөв.Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт *тогтоолын төслийг танилцуулав.*

*Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.*

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./12:20/*

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

**Бусад.** Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын урилгаар Баянгол дүүргийн Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын хэлтсийн ажилтнууд, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын урилгаар Төв аймгийн Аргалант, Эрдэнэсант сумын Соёлын төвийн ажилтнууд, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбатын урилгаар Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчдын төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 2 цаг 19 минут үргэлжилж, 126 гишүүнээс 108 гишүүн хүрэлцэн ирж, 85.7 хувийн ирцтэйгээр 12 цаг 20 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

*2026 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр, Пүрэв гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 01 минут*

### **НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

---

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая. Чуулганы хуралдааны ирц 84 гишүүн буюу 66.7 хувийн ирцтэй бүрдсэн байгаа тул 2026 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Төрсөн өдөр нь энэ өдрүүдэд тохиолдож байгаа гишүүдийн мэндчилгээг та бүхэндээ бас мэдээллийг хүргэе.

4 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабал гишүүн төрсөн байна.

4 дүгээр сарын 13-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн төрсөн байна.

Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабал, Даваахүүгийн Пүрэвдаваа нарт төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлын нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хамгийн эхэнд ирсэн, ирцдээ орсон гишүүдийг танилцуулъя. 5 гишүүнийг бас танилцуулна. Баярмагнай Баярбаатар гишүүн өглөө 9 цагт ирсэн байна. Агваанлуvsсангийн Ундраа гишүүн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн, Буланы Бейсен гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүд бас хамгийн түрүүлж чуулганы хуралдаандаа хүрэлцэн ирж, ирцдээ орсон байна.

Та бүхэнд цагтаа ирж, Улсын Их Хурлын гишүүддээ хариуцлагатай, бас ёс зүйтэй, цаг барьдаг байхыг баримталж байгаад талархал илэрхийлье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар дараах 4 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт нь Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Монгол Улсын Ерөнхийлөгч 2026 оны 3 дугаар сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төсөл байгаа.

Хоёрдугаарт нь Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга нарын 8 гишүүн 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг хийнэ.

Гуравдугаарт нь “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

“Газар зүйн нэрсийн жагсаалт батлах тухай” Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 42 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг Засгийн газар 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх асуудлыг шийднэ.

Дөрөвдүгээрт нь “Бусад” асуудлын хүрээнд “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” асуудлыг хэлэлцэнэ.

Энэ “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах” асуудал дээр Монгол Ардын намын бүлгийн даргаас бичиг ирсэн. Энэ дээр өөрчлөлт байгаа юу? Бичгээ өөрчлөх үү, хойшлуулах уу, үгүй юү? Энэ “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” асуудал Тамгын газар энэ ер нь бэлэн болсон уу? Болох уу тээ? Ийм 4 асуудлыг хэлэлцэх нь байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы, ингээд зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатарын урилгаар Баянгол дүүргийн Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын хэлтсийн албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхнийхээ ажилд нь амжилт хүсэж, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг нийт гишүүдийнхээ өмнөөс хүргэе.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж танилцуулсан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг нарын 8 гишүүн 2026 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд хуваарилсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.1-д хууль санаачлагч хэлэлцүүлгийн аль ч шатад санаачилсан хуулийн төслөө татан авч болно гэж, 32.3-д хуулийн төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатад байгаагаас үл хамааран хууль санаачлагч хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцно гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр Хуулийн төслийг татан авах тухай Засгийн газрын 1/30 дугаартай албан бичиг ирүүлснийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газар 2026 оны 4 дүгээр сарын 09, Монгол Улсын Их Хурлын дарга Сандагийн Бямбацогт танаа, Хуулийн төслийг татан авах тухай, Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулж Улсын Их Хуралд 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл,

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

Хувь хүний орлогын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д заасны дагуу татан авч байгааг үүгээр уламжлан мэдэгдэж байна.

Засгийн газрын 2026 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг хавсаргав. Монгол Улсын Ерөнхий сайд Учрал гэсэн байна.

Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

Хувь хүний орлогын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл;

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг тус тус татан авсанд тооцлоо.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр ажлын 1 өдрийн завсарлага авсан.

Завсарлагын хугацаа дууссан байна. Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн даргаас үг хэлэх үү? Цогтгэрэл даргын микрофон өгье.

**О.Цогтгэрэл:** Энэ хэлэлцэж байгаа асуудал буюу Улсын Их Хурлын гишүүнийг эргүүлэн татахтай холбоотой асуудлаар Ардчилсан намын бүлгээс завсарлага авсан. Ардчилсан намын бүлэг дээр энэ асуудлыг бас бид нар тал талаас нь удаа дараа ярилцсан. Бас энэ дээр ярилцаад гарсан нэгдсэн байр суурь, олонхын шийдвэр нь тухайн хуулийн заалт нь, зарим заалтууд нь Үндсэн хуулийн суурь үзэл санаатай зөрчилдсөн, Үндсэн хуулийн зарим заалтуудыг бас зөрчсөн байж болох ийм үндэслэлүүд бас байна нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь, зарим гишүүдэд бас ярьж байгаа нь хэлэлцэх эсэхийг нь дэмжээд явцын дунд засъя гэдэг байр суурийг зарим гишүүд бас илэрхийлж байна лээ. Энэ бол яг энэ хуулийн үндсэн баримталж байгаа бодлого нь Улсын Их Хурлын гишүүнийг ёс зүйн гэх зэрэг хэмжиж болшгүй зүйлээр нэгдүгээрт нь дүгнэлт гаргаад энийг Үндсэн хуулийн цэцээс Улсын Их Хуралд танилцуулснаар шүүхийн байгууллагаас Улсын Их Хуралд хүргүүлснээр энэ тогтоол хүчинтэйд тооцогдоно.

Улсын Их Хурал энийг хэлэлцэн шийдвэрлэх буюу тэр Үндсэн хуулийн тэр үндсэн үзэл санааг, ард түмний төлөөллийн мандатыг үндсэндээ ийм улс төрийн шүүх байгууллагаар шийдэх ийм боломж бололцоо, хаалга, үүдийг нээж өгч байна. Энэ бол хэлэлцүүлгийн явцад засах ямар ч боломж, бололцоогүй заалт юм гэдэг дээр бас олон гишүүд санаа, бодлоо тодорхой илэрхийлж байсныг бас энд бас ингээд дурдах нь зүйтэй байх.

Ардчилсан намын өөрийнх нь үзэл баримтлалын үндэс нь, үндсэн үзэл баримтлалын өгүүлбэрээс би бас дахиад олон нийтэд болоод гишүүддээ уншихъя.

Ардчилсан намын үзэл баримтлалд тусгаар тогтнол, үндэсний язгуур ашиг сонирхлыг эрхэмлэн ардчилсан ёс, Үндсэн хуульд парламентын засаглалаа бататгахыг чухалчилна гэж бид бүгд заасан. Тэгэхээр Ардчилсан намын мандатаар Ардчилсан намыг төлөөлж бас Улсын Их Хуралд сууж байгаа эрхэм гишүүд та бүхэн бас Үндсэн хууль болоод бусад хуулиуд тэр тусмаа бас өөрсдийнхөө бид нар үзэл баримтлал гэж чухалчлан баталсан энэ үзэл баримтлалынхаа үндсэн зарчмыг бас сахиж бас итгэл үнэмшлээрээ асуудалд хандахыг та бүгдээсээ бас хүсье.

**С.Бямбацогт:** Цогтгэрэл дарга завсарлагын хугацаа сунгахгүй гэдгийг, бас хугацаа дууссан гэдгээ хэллээ.

Одоо Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлдэнэ. Бэлэн болсон 88 гишүүн байна. Бэлэн бус 13 гишүүн байна. Нийтдээ 101 гишүүн. Алдаржавхлан, Алтанхуяг, Амарбаясгалан, Замира, Идэрбат, Лүндэг, Найдалаа, Номин, Тэмүүжин, Ундраа, Хэрлэн, Чойжилсүрэн, Энхтүвшин гишүүд энэ бас нэлээн чухал асуудал хэлэлцэж байгаа. Ард иргэд, олон нийт, парламентын засаглалыг бэхжүүлэх, Улсын Их Хурлын гишүүдийг бас хариуцлагатай, ёс зүйтэй, ажилдаа цагтаа ирчихдэг, ирцдээ ороод саналаа өгчихдөг, асуудлаа хурдан шийдчихдэг байгаасай, хууль зөрчдөггүй байгаасай гэж их хүсэж байгаа. Улс төржөөгүй би. Тийм болохоор санал хураалтдаа бүрэн оролцъё гэж байна. Тийм юм байхгүй шүү.

93 гишүүн бэлэн болсон байна. Санал хураалтад бэлтгэл хангагдаагүй гишүүд байна уу? Санал хураалтыг хариуцлагатай болгох асуудал ярьж байна би. Манипуляц хийсэнгүй. Санал хураалт явуулах уу? Ирцийн санал хураалт. Ирцийн санал хураалт.

Ирцийн санал хураалтад Оюун-Эрдэнэ гишүүн ирцдээ орох юм уу та? Ирцдээ орчихсон бол. Санал хураалт явуулахад ямар нэгэн асуудлаар намайг санал хураалтад оролцуулах боломжийг хангасангүй гэдэг асуудал үүсэхгүй биз дээ энэ ирцдээ ороогүй гишүүд? Чиглүүлсэнгүй. Тэгвэл санал хураалт.

Санал хураалтад 57 гишүүн гэж юу бэ. 101 гишүүн оролцсоноос 57 гишүүн зөвшөөрч, татгалзсан 44, 56.4 хувийн саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Ерөнхий сайд санал хураалт явах гэж байна шүү. Санал хураалт.

Санал хураалтад 101 гишүүн оролцсоноос 56 гишүүн буюу 55.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Санал хураалтад 101 гишүүн оролцсоноос 55 гишүүн буюу 54.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.“Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын

томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд жоохон ёс зүйтэй байцгаана шүү. Бас бие биедээ хүндэтгэлтэй хандъя. Энэ дүнг танилцуулсан билүү?

Санал хураалтад 101 гишүүн оролцсоноос 55 гишүүн буюу 54.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

Засах, сайжруулах асуудлууд байвал анхны хэлэлцүүлэг, эцсийн хэлэлцүүлгийн шатад бас засах, сайжруулах боломж байгаа. Хуулийг эцэслэн батлахдаа бид нар бас нийт гишүүдийн олонхын саналаар бас баталдаг. 64 гишүүний саналаар. Тийм болохоор бас Их Хурал илүү бас энэ парламентын засаглалыг бэхжүүлэх, Улсын Их Хурлын гишүүдийг бас сахилгатай, хариуцлагатай, ёс зүйтэй байх, Улсын Их Хурлын нэр хүндийг өсгөх, ард түмний бас төрд итгэлийг нэмэгдүүлэхэд илүү бас хариуцлагатай анхны хэлэлцүүлэг, эцсийн хэлэлцүүлгийг хийж, эцсийн энэ хуулийг бас батлахад анхаарна байх гэдэгт найдаж байна. Дараагийн асуудалдаа оръё.

10.23 цаг

**Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.**

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**С.Зулпхар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Д.Рэгдэл, Г.Хосбаяр нараас 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2025 оны 12 дугаар сарын 12, 18-ны өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд:

Үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан ажиллуулах;

Эрдэм шинжилгээ, судалгаа, хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэгч нь уг ажлыг дууссанаас хойш 90 хоногийн дотор Үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санд хүргүүлж ил тод, хүртээмжтэй байлгах;

Хууль хоорондын зөрчилтэй болон агуулгын хувьд давхацсан зарим заалтыг хасах зэрэг саналын томъёолол гарсныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд дэмжлээ.

Мөн Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 23.4 дэх хэсгийг өөрчлөн найруулах тухай саналаа ажлын хэсэг татсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа, Д.Рэгдэл нар Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 23.4 дэх хэсгийг хуулийн төслөөс хасах санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Шинжлэх ухаан технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Б.Найдалаа.

**С.Бямбацогт:** Сархадын Зулпхар гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Шинжлэх ухаан, технологийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд ажлын хэсэг анхны хэлэлцүүлэг хийж байгаа.

Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү дарга. Хаа байна? Батхүү даргыг дуудна. Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандах ёстой. Ажлын хэсэгт орсон бол ажилдаа Улсын Их Хуралд

ирж бас ажлаа хийх ёстой шүү. Баатарын Туул Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга. Энхболд дарга хаа байна? Дуудаарай. Батнасангийн Бат-Эрдэнэ Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны дарга. Бүдээбазарын Авид Шинжлэх ухааны академийн Дэд ерөнхийлөгч.

Ирээгүй ажлын хэсгийн гишүүдийг дуудъя. Ажлын хэсгийн гишүүдэд, бас Их Хурлын гишүүдэд хууль бас танилцуулъя. Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан болон бусад этгээд үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй.

21.25.Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худалд мэдээлэл ирүүлэхийг хориглоно гэж тус тус заасныг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд танилцуулъя.

Энэ дэгийн хуульд бас Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандаагүй, ажлын хэсэгт орчхоод хуралдаа, чуулганд ирж оролцоогүй, Байнгын хорооны хуралдаанд бол бас хариуцлага тооцох энэ заалтыг оруулах ёстой энэ бас байх ёстой шүү гэдгийг бас хэлье.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна..

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

**Д.Энхтүвшин:** Энэ хуулиар Шинжлэх ухаан, технологийн тухай хууль дээр хувийн хэвшлийн оролцоо болон төрийн дэмжлэг, санхүүжилтийн эрх зүйн үндсийг тогтоох харилцааг зохицуулна гэсэн энэ агуулгын хүрээнд энэ хуулийн төсөл орж ирсэн юм байна гэж ойлгосон. Тэгэхээр өөрөөр хэлбэл, төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагуудыг дэмжих, тендерт ороход нь илүү амар хялбар болгох гэсэн иймэрхүү заалтууд орж ирсэн байна лээ. Тэгээд энэтэй холбогдуулаад ер нь энэ шинжлэх ухаан, технологитой холбоотой асуудал ер нь сүүлийн жилүүдэд хаягдчихсан байгаа. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хэлэлцэхэд, 2 жилийн үр дүн хэлэлцэхэд энэ асуудал маш хангалтгүй байгаа ийм дүр зураг байгаа.

Жишээлбэл, би энэ шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны зардлыг ДНБ 1 хувьд хүргэнэ. Суурь түвшин 0.11, 2025 оны зорилтот түвшин 0.12 гээд, хүрсэн түвшин нь 0 байсан. Дээр нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль дээр 22.9.8 дээр их, дээд сургууль, Шинжлэх ухааны академид судалгаа, шинжилгээний зориулалтаар олгосон тэтгэлгийг чөлөөлөхөөр, энэ 1 хувийн татвартай холбоод чөлөөлөхөөр ийм заалт орсон боловч энэтэй холбоотой журам нь одоо болтол гараагүй байгаа. Тэгээд энэ журмыг хэзээ гарах вэ гэдгийг бас түрүүчийн хуралдаанууд дээр асуугаад хариулт авч чадаагүй. Дахиад Эдийн засаг, хөгжлийн яамнаас хүн байгаа бол энэ талаар хариулт өгөөч.

Энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт байгаа шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны зардлыг ДНБ-ий 1 хувьд хүргэнэ гэсэн зорилтыг ямар, яаж хангахаар яаж ажиллаж байгаа энэ талаар бас мэдээлэл өгөөч ээ.

**С.Бямбацогт:** Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 4 дүгээр индэр дээрээс хариулъя. Ажлын хэсгийн гишүүн хариулаарай. Ажлын хэсгийн ахлагч бас хариулж болно. Сархадын Зулпхар гишүүн эхлээд хариулчих уу та дараад нь.

**С.Зулпхар:** Энхтүвшин гишүүнд баярлалаа. Маш чухал асуудлыг та хөндлөө. ДНБ-ий 1 хувь руу шинжлэх ухааныхаа зардлыг хүргэх ийм зорилт тавьсан. Гэхдээ өнөөдрийн байдлаар ДНБ-ий 0.1 хувь байгаа юм. Үндсэндээ энэ бидний тавьсан зорилтод яагаад ч хүрээгүй ийм байдал.

Нөгөөтээгүүр Улсын Их Хурал дахь Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнд байгаа Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооныхон сая намрын чуулганы завсарлагаагаар шинжлэх ухааны хүрээлэнгүүдээр явж ажилласан. Их сургуулиудаараа бас очиж ажилласан. Тэгээд энэтэй холбоотой тухайлсан саналууд гарсан байгаа. 11 санал гарсан байгаа юм. Тэр нь бол шинжлэх ухааны байгууллагын хөрөнгө оруулалт, хүний нөөц, цалин хөлс, тэрнээс гадна шинжлэх ухааны байгууллагын хүний нөөцийн өргөн хөгжлийн асуудал гээд ингээд цогц зүйл байгаа юм. Энэ бүхнийг шийдэж байж бид тодорхой салбарын бас хөгжлийг урагшлуулах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байгаа юм.

Тэгээд энэтэй уялдсан байдлаар дэд хорооноос Байнгын хороогоор уламжлуулан Эдийн засаг, хөгжлийн яаманд 11 жишээ нь санал бүхий бид ийм дүгнэлт хүргүүлсэн. Тэр дүгнэлтийг бид Монгол Улсын Их Хурлаас тогтоол болгож гаргах ёстой гэж ойлгож байгаа юм. Энэ тогтоолын дагуу бид ажиллах ёстой.

Жишээ нь хамгийн энгийн тодорхой зүйлийг ярья. Манай эдийн засгийн гадаадын экспортын 80 хувь уул уурхайн салбараас байдаг. Уул уурхайн жишээ нь чиглэлээр 2 хүрээлэн байгаа юм. Геологийн хүрээлэн, Уул уурхайн хүрээлэн гэж. Геологийн хүрээлэнгийн сүүлийн 5 жилийн судалгааны зардал нийт өөрийнх нь төсөв нь 1 тэрбумаас хэтрээгүй. Судалгаа биш ихэнх нь бол урсгал зардал нь болоод л явчихсан. Гэтэл бид нар геологийн хайгуул, судалгаа бол үндсэндээ өнгөрсөн жилүүдэд хийгээгүй ийм нөхцөл байдалтай байгаа.

Тэгэхээр энэ чиглэлээр бид анхаарч байж цаашдаа эдийн засгийн суурь болсон уул уурхайн салбарын бас хөгжлийг хангах юм байна гэдэг ийм олон жишээнүүд гарчхаж байгаа юм. Тийм учраас энэтэй уялдсан байдлаар бид тогтоолын төсөл оруулахаар ямар ч байсан бэлтгэл хангана. Тэгээд энэ дээр та бүхэн бас дэмжиж өгөөрэй гэж байгаа юм. Шинжлэх ухаандаа анхаарахгүйгээр бид бол хөгжлийн тухай ярих ямар ч боломжгүй.

Мал аж ахуйн эмнэлэг, эрүүл мэндийн хүрээлэн дээр очиход вакцинууд нь бэлэн болчихсон. Энийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ямар ч схем байхгүй. Үүнтэй уялдсан жишээ нь зохион байгуулалтын үндэс тавигдаагүй, зардал мөнгө байхгүй ийм нөхцөлтэй л байж байгаа. Тэгэхлээр энэ чиглэлээр бид тухайлан анхаарна тэр битгий хэл жишээ нь хувийн хэвшилтэй түншлэх тодорхой тухайлсан схемүүдийг бас тодорхой болгох ёстой гэсэн ийм саналууд гарч байгаа гэдгийг хэлье. 66 хүрээлэн байгаа. 66 хүрээлэнтэй бид бүгдтэй нэгдсэн байдлаар уулзсан.

Тухайлсан хүрээлэнгүүдээ бид сонгож 8 хүрээлэн дээр очиж ажилласан байгаа. Ингээд таны хэлсэн зүйл нотлогдож байгаа. Энийг бид бүгдээрээ хамтдаа анхаарах ёстой гэсэн ийм чигтэй байна.

**С.Бямбацогт:** Ажлын хэсэг нэмээд хариулчихъя. 4 дүгээр индэр.

**Б.Туул:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22, 9-тэй холбоотой манайх манай асуудал эрхэлсэн сайд шаардлагаа баталсан. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Сангийн яамтай зөвшилцөөд дахин баталж ирүүл гэсний дагуу бид Сангийн яамтай зөвшилцөөд төслийг эцэслэн боловсруулсан. Одоо Захиргааны хэрэг ерөнхий хуулийн дагуу бид олон нийтээс санал авах явцтай явж байна.

**С.Бямбацогт:** Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн нэмэлт асуулт асууя.

**Д.Энхтүвшин:** Энэ шинжлэх ухаан, технологи хөгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоо яг энэ татварын энэ саяын хууль маш чухал үүрэг рольтой хуулийн заалт байгаа. Энэ чиглэл хууль маань батлагдаад бараг 2 жил болчихсон байхад ингээд бараг хамгийн сүүлд танай энэ журам явж байгаа. Шинжлэх ухаанд бас ямаршуу байдлаар хандаж байгаа нь энэ төсөвт тавьж байгаа дүн, энэ дагасан хуульд хандаж байгаа байдал эд нараас л харагдаад байгаа л байна л даа.

Тэгээд энд дагасан хуультай холбоотой нэг асуулт байна. Төрийн болон орон нутгийн өмчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт гээд. Энэ хуулийн үйлчлэх хүрээнээс энэ төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагын шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн ажлыг харилцааг энэ хуулийн хүрээллээс гаргахаар заачихсан мөртөө сүүлд нь ард талд нь баталгаатай холбоотой, гүйцэтгэлийн баталгаа болон тендерийн баталгаатай холбоотой 2 заалтыг.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргалын урилгаар Төв аймгийн Аргалант, Эрдэнэсант сумын Соёлын төвийн ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа гишүүдийн нэрийн өмнөөс амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Ажлын хэсгийн ахлагч Сархадын Зулпхар гишүүн хариулъя. Эрдэнэболд гишүүн маань тэнд сууж байна. Бас та бүхний сонгогдсон Төв аймгийн гишүүн.

**С.Зулпхар:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Таны хэлдэг гарцаа байхгүй зөв. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулиар бол таны саяын хэлсэнчлэн тодорхой үндсэн чиглэлийн судалгаанууд дээр шинжлэх ухааны байгууллагууд оролцоход Тендерийн тухай хууль үйлчлэхгүй байхаар ийм зохицуулалт байж байгаа юм. Тэр нь үндсэн чиглэлийн судалгаанууд дээр шууд холбогдох чиглэлийн судалгааг нь хийлгээд явдаг ийм зохицуулалт бий.

Нөгөөтээгүүр бол төрийн байгууллагуудад гарцаа байхгүй тендер зарлаж авдаг ийм судалгаа болон тооцооллын үнэлгээ хийдэг ийм ажлууд байгаа юм. Тэгэхлээр тэрийг бол бас мэргэжлийн хүрээлэнгүүд хийх ёстой байдаг. Мэргэжлийн хүрээлэнгүүд энэ ажлуудад орох гэхлээр зэрэг тендерийн баталгаа шаарддаг. Энэ тендерийн баталгаа шаардана гэхлээр зэрэг нөгөө хүрээлэнгүүд маань өөрсдөө төсвөөс авч байгаа зүйл нь урсгал зардал, тэгээд цалин хөлснөөс цааш хэтэрдэггүй учраас энэ тендерүүдэд орж чаддаггүй. Эсрэгээр нь өөр жишээ нь байгууллагууд магадгүй ТББ шиг.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Хариултаа дуусгачихъя. Сархадын Зулпхар гишүүнд 1 минут.

**С.Зулпхар:** Ийм байгууллагад ордог нөхцөл байдал үүссэн учраас шинжлэх ухааны байгууллагуудын мэргэжлийн түвшинд судалгаа хийх, энэ оролцоог нэмэгдүүлэх, оролцоог нээх зорилгоор энэ зохицуулалтыг Төрийн өмчөөр бараа, бүтээгдэхүүн худалдан авах тухай хуульд нэмэлтээр оруулж өгсөн юм байгаа юм. Энэ манай Улсын Их Хурлаас бидний зорилго болгосон чөлөөлье гэсэн зорилттой бол шууд нийцэж байгаа. Шинжлэх ухааны салбарт бас тодорхой түвшний бид ийм чөлөөлөлт авчирч байгаа ийм хэлбэр юм байгаа юм.

Нөгөөтээгүүр шинжлэх ухааныхаа салбарыг бас хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байгаа бас ийм зохицуулалт болж байгаа гэдгийг танд бас тэмдэглэж хэлье.

**С.Бямбацогт:** Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

**М.Ганхүлэг:** Асуулт асуухаасаа өмнө байр сууриа хэлэхгүй бол бас болохгүй нь. Маш харамсалтай өдөр тохиож байна. Үндсэндээ ганц хүний засаглал руу, дарангуйлал руу явж байгаа алхам бий болж эхэллээ.

**С.Бямбацогт:** Эрхэм гишүүн ээ бас хэлэлцэж байгаа асуудалтай холбогдож асуулт асууна.

**М.Ганхүлэг:** Би бас холбогдуулж асууна дарга. Харамсаж байна Их Хурлын даргаа. Парламентынхаа эсрэг даргатай байгаадаа харамсаж байна. Ардчиллынхаа эсрэг байгаа Ардчилсан намынхаа гишүүддээ бас харамсаж байна. Бас энэ өөрсдийнхөөрөө саналаа өгч чадахгүй байгаагаа бас ах нараасаа эмээж байна, бас харамсаж байна.

Ер нь Монгол Улсад энэ шинжлэх ухаан, аливаа зүйл зарчмынхаа дагуу явж чадахгүй байгаагийн тод илрэлийг сая бид бүгд өөрсдөө бас харууллаа л даа. Тэгээд Их Хурлын даргын хувьд түүхэнд маш тодоор, хараар бичигдэх ийм үйлдэл бас боллоо гэдгийг би бас харамсаж байгаагаа бас хэлчихье. Жинхэнээсээ л сүрээр дарах жилдээ сүрээр даруулж эхэлж байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолтой. Ер нь Монгол Улсад энэ шинжлэх ухаанаа хөгжүүлэх юм уу, үгүй юм уу? Энэ судлаачдаа сонсох юм уу үгүй юм уу? Бусад энэ улс орныхоо энэ жишиг дэлхийд байхгүй жишгээр бид нар ингээд шийдвэр гаргаад л явж байна. Ардчилсан орон хэзээ ч ийм шийдвэр гаргадаггүй. Тэгээд энэ хамгийн судлаач мэргэжлийн гишүүд маань хүртэл энийг дэмжээд явж байгаад бас л харамсаад байгаа юм.

Тэгээд 1 хувь гэдэг юмыг бид нар гаргасан. Үүнээс хойш жил болгон энийгээ бид нар дүгнэж явж байгаа юм уу, үгүй юм уу? 2002 онд 0.08 хувь гэж. Тэгээд энэ хууль батлагдсанаараа шинжлэх ухааны салбарт оруулж байгаа энэ 1 хувь яаж өөрчлөгдөх юм бэ, тэр рүүгээ очих юм уу гэдэг эхний асуулт байгаа.

Бусад олон улсын байгууллагууд олон улсын жишгүүдийг ингээд харахаар ДНБ-ий OECD-гийн орнууд үндсэндээ 2.7 хувь, Европын холбоо 2.1 хувь, Израил 6.8 хувь, Бүгд Найрамдах Солонгос Улс 5.1 хувь гээд үзүүлэлтүүдийн хувьд шинжлэх ухаандаа хөрөнгө оруулдаг улс орнуудын хөгжлийн ялгаа бусад түвшнүүд үүнтэйгээ хамаараад бас өөр байгаа. Тэгэхээр энэ гол үндсэндээ ярьсан асуудал яагаад хэрэгжихгүй байгаа юм, энэ хууль батлагдсанаараа ямар үр дүнд очих юм бэ гэдэг эхний асуулт байгаа юм.

Хоёр дахь нь энэ хууль дээр бас тодорхой заагдаж байгаа бэлтгэсэн улсын зардлаар хийгдсэн энэ судалгаа, мэдээллүүдийг нэгдсэн платформд оруулаад энийгээ ашигладаг давхардлыг би арилгасан ийм хэлбэр рүү орно гэдэг зохицуулалтууд байна. Энэ нь сайшаалтай.

Гэхдээ зөвхөн платформ гэж харахгүйгээр илүү сайжруулах, илүү захиалга, хэрэгцээг хангах чиглэлийн бусад өөр нарийвчилсан зохицуулалтууд дээр бид нар яаж ажиллах юм бэ? Веб сайт хийгээд веб сайтдаа судалгаануудаа оруулаад ингээд дуусчих юм биш биз дээ гэсэн ийм хоёр дахь асуулт байгаа юм.

Гурав дахь нь судалгааны их сургуулийг дэмжсэн гол зохицуулалтыг дэмжиж байгаа. 18.2.2 дахь заалт дээр судалгааны их сургууль гэж өөрчлөхөөр тусгасан байгаа. Гэтэл бодит байдал дээр бид бүхэн одоогоор судалгааны сургуулиудгүй байгаа. Тэгэхээр энийг дагаад энэ сургуулиудын статус, үүнтэй холбогдолтой асуудлууд яаж шийдэгдэх юм бэ, энэ рүү шилжихэд ямар асуудал байгаа юм бэ гэдгийг бас тодруулъя. Зөвхөн улсаас татаас авахгүйгээр төрийн өмчийн сургуулиуд сурагчдынхаа төлбөр дээр үндэслэж үндсэндээ явж байгаа.

Тэгэхээр энэ судалгааны сургууль болох олон талын энэ эх үүсвэрийг бий болгох чиглэл дээр алхам хийх гэж байгаа нь зөв. Гэхдээ энийг ингээд бид нар одоогоороо хуулиа нээчихсэн хэр нь хийж чадахгүй байгаа шалтгаан юу юм бэ? Энэ дээр бас тодорхой бид нар хариуцлагуудыг, тодорхой асуудлуудыг нь шахаад ингээд явах ёстой. Энэ 3 гол асуудлыг яг яаж шийдэх вэ гэдгийг бас тодорхой болгох нь энэ хуулийн гол чухал үзүүлэлт ээ гэж бас ойлгож байна. Энэ дээр хариулт авъя.

**С.Бямбацогт:** Сархадын Зулпхар гишүүн, ажлын хэсгийн ахлагч хариулъя

**С.Зулпхар:** Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Маш чухал асуудлыг та бас хөндөж байна. Ажлын хэсэг дээр ч гэсэн энэ яригдсан, дэд хороон дээр ч гэсэн яригдсан, манай Байнгын хороон дээр бас байнга яригдаж байгаа зүйл учраас би бас зориуд бас зарим тоо хэлье гэж бодож байгаа юм.

Өнгөрсөн жил бид 2026 оны төсвийг батлах үедээ Шинжлэх ухаан, технологийн сангаар дамжуулж хийдэг судалгааны зардалд 10 тэрбум төгрөг баталсан. Энэ өөрөө их хамгийн том бидний бас ний нуугүй хэлэхэд хариуцлагагүй

бас үйлдлүүдийн нэг байсан. Оруулж ирсэн төсвийг нь хасчихсан. 10 тэрбум гэдэг үндсэндээ 4-5-хан километр л хатуу хучилттай авто зам шүү дээ. Бид шинжлэх ухаанд ингэж л хандаж байгаа. Судалгаан дээр нь шүү дээ. Бусад зардлыг нь би хэлээгүй. Нийтдээ бол 156 тэрбум төгрөг байгаа юм. Энэ салбарын нийт зардал. 66 хүрээлэн байгаа шүү дээ.

Тэгэхлээр таны хэлдэг гарцаа байхгүй үнэн. Сая тэр гаднын улсуудын жишгийг хэлж байна. Хамгийн өндөр нь Израил байгаа. Тэгээд энэ өндрүүдийн нэг нь Америк байгаа. 3.4 хувь байдаг шүү дээ ДНБ-ий. Ингэж байж улс орон хөгждөг учраас бид бас өнгөрсөн хугацаанд энд анхаарч ирсэн. Сүүлийн шинэ жилүүд бид энд дорвитой анхаарч чадаагүйгээс болоод энэ хүндрэл гарч байгаа.

Цалинг нь ярих юм бол улсын цалин дундаж цалингаас 1.7 дахин бага байгаа шүү дээ эрдэм шинжилгээний ажилтнуудын. Хамгийн өндөр мэргэжилтэй улсууд гэж байгаа юм. Тэгэхээр бид ирэх жил бол энэ хуулийн саяын зохицуулалтаар бол 70-аад тэрбум төгрөг байгаа юм судалгааны ажлын. Одоо орж чадахгүй байгаа гэсэн үг шүү дээ. Тэгэхлээр зэрэг хүрээлэнгүүдэд 70-аад тэрбум төгрөгийг нь төрийн байгууллагуудаар дамжсан энэ судалгааны болон тооцоолол хийх, шинжлэх ухааны үндэслэлийг гаргах, үнэлгээ хийх энэ ажлуудад орох боломжийг нь нээж байгаа юм. Тэгэхлээр зэрэг энэ хүрээлэнгүүдэд бас зохих түвшний бас боломж нээх байх гэж байгаа юм.

Гэхдээ энэ хангалттай биш. Бид одоо төсвийн хүрээний мэдэгдэл орж ирэх гэж байна. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр бид шинжлэх ухаан, технологийн зардлыг тэр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн бидний дүгнэлтээр бол манай Байнгын хороогоор дамжуулж хүргүүлсэн дүгнэлт шүү дээ. 3-4 дахин багадаа, дээд тал нь бол 4-6 дахин нэмэх ийм санал оруулж байгаа юм. Энийг та бүхэн бас дэмжиж өгөөрэй. Тэгэхгүй бол хүрээлэнгүүд дээр үндсэн чиглэлийнхээ судалгааг ч хийж чадахгүй байна. Энэ бол нэгдүгээр асуудал.

Хоёр дахь зүйл бол энэ мэдээллийн сан гарцаа байхгүй чухал. Салангид салангид баахан мэдээллийн сан байдаг. Тэр мэдээллийн сангаар дамжуулаад бид нар энэ судалгаануудыг ашиглах боломжгүй болчихоод байгаа юм. Хаана ямар судалгаа байгааг бараг мэдэж байгаа хүнгүй учраас. Энийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Мори” гэдэг том жишээ нь платформтой болно гээд ингээд зорилго болгосон юм байна лээ. Тэгэхлээр энийг бид Шинжлэх ухаан, технологийн сан дээр өөр дээр нь байж байгаа мэдээллийн сан дээр суурилсан байдлаар хөгжүүлэлтийг нь хийгээд энэний ашиглалтыг нь бол бүрэн болгоно гэж байгаа юм. Хувийн хэвшил, төрийн байгууллагууд бүрэн ашиглах иргэд ашиглах боломжтой.

Гэхдээ мэдээж хэрэг энд ашиглалттай холбоотой судалгааны үр дүнг зарим нь бол хаалттай зүйлүүд байдаг. Зарим нь хагас хаалттай зүйл байдаг. Бүрэн нээлттэй зүйл байдаг. Энийг тухайн байгууллага өөрөө зохицуулаад явахаар бас энийг бид бас ажлын хэсгийн хүрээнд, тэрнээс гадна Байнгын хороон дээр хийсэн гэдгийг танд бас мэдээ дуулгая.

Гурав дахь зүйлийн тухайд энэ судалгааны их сургуультай холбоотой асуудал юм байгаа юм.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Асуултаа гүйцээгээд хариулчихъя. 1 минут Сархадын Зулпхар гишүүн, ажлын хэсгийн гишүүн, ахлагч.

**С.Зулпхар:** 2023 оны 7 сард батлагдсан боловсрол шинжлэх ухааны жишээ нь салбарын тухай бид хуулийн эрх зүйн шинэчлэл хийсэн. Үүний дагуу судалгааны их сургуулиудаа болгохоор ийм хуулийн шинэ үндэслэл бий болсон. Энэ сургуулийг байгуулахтай холбоотой асуудлыг төрийн захиргааны төв байгууллагад нь чиглэл болгочихсон байгаа. Судалгааны их сургуулийн хууль оруулж ирэхээр тийм чиглэл болгосон байгаа. Тэгэхлээр энэ асуудал бол Боловсролын яаман дээр энэ асуудал өөрөө бэлтгэгдэж байгаа гэж ойлгож байгаа.

Тэгэхлээр зэрэг бид энэ удаагийн хууль дээр бол судалгааны их сургууль гээд хуульд байхгүй, байгуулагдсан зүйл байхгүй учраас энэ хууль дээр энийг оруулж чадаагүй. Өөрөөр хэлбэл, эрх зүйн хувьд энд боломжгүй учраас энд хасчихсан. Гэхдээ цаашдаа бид энийг хуульд батлагдсан нөхцөлд энийгээ анхаараад явах зайлшгүй шаардлага байна.

**С.Бямбацогт:** Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн тодруулж асууя.

**М.Ганхүлэг:** Эхний асуудал дээр яагаад 1 хувьд хүргэхгүй байна вэ гэдэг дээр яг тодорхой дүгнэлт яг өнөөдөр бас хийгээд авах нь зөв байх. Үнэхээр шинжлэх ухааны байгууллагууд 1 хувийн санал төсөв дээр оруулж ирээд бид хассан юм уу, эс үгүй бол анхнаасаа бага санал оруулж ирээд ингээд үндсэндээ явсан юм уу гэдгийг эргээд яг тодорхой танилцуулаач. Өнгөрсөн оны төсвийн төсөл дээр Засгийн газраас орж ирсэн төсөл яг хэдэн хувиар шинжлэх ухаан руу зарцуулна гэж орж ирсэн юм, Их Хурлын гишүүд яг хэдэн хувь болгож хассан юм гэдгийг тодорхой яг энэ хууль яригдаж байгаатай холбогдолтой хэлээд өгчхөөч ээ гэж хүсэх байна.

Эндээс үндсэндээ олон гишүүд их шинжлэх ухаанаа хасъя, энэ рүү зориулахгүй больё энэ тэр гэдэг ийм хандлага бол би байхгүй байгаа гэж бодож бодож байгаа юм. Яг гүйцэтгэл, зохион байгуулалт, энийгээ ойлгуулж ажиллах тал дээрээ бид нар бас алдаа гаргаж байна. Тэгэхээр яг энэ чиглэлийнхээ дүгнэлтийг саяын өнгөрсөн жил дээрээ хэдүүлээ харьцуулж хараад цаашдаа яах вэ гэдгээ бас яриад авах нь зөв үү гэж бодож байна.

**С.Бямбацогт:** Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн ахлагч хариулъя Сархадын Зулпхар гишүүн.

**С.Зулпхар:** Өнгөрсөн жил бид бол анхаарсан. Шинжлэх ухааны ажилтнуудын цалинг бид 15-аар нэмэх санал орж ирснийг хамтдаа бид дэмжээд явуулсан. Энэ батлагдсан. Миний саяын хэлсэн бол судалгааны зардал Шинжлэх ухаан, технологийн сангаар дамжиж орж ирж байгаа юм. Энэ дээр бол багавтар зардал орж ирсэн. Үндсэндээ 35, 30 тэрбум руу хүргээд оруулаад ирснийг нь бид нар 10 тэрбум болгоод хасчихсан юм. Энэ гэхдээ их маш бага зардал шүү дээ.

Нөгөөтээгүүр хүрээлэнгүүд энэ 66 хүрээлэн дотор бол бас судалгааны зардлуудаа нэмж оруулж ирсэн саналаа өгсөн. Энэ Эдийн засаг, хөгжлийн яам дээр өөр дээр нь бол энэ хасагдсан. Бидэн дээр ирэхэд бол угаасаа маш бага дүнтэй орж ирсэн. Цаашдаа бид энийг бол өндөр дүнтэй байлгах чиглэлээр саяын

хэлсэн 11 дүгнэлт дотор энэ байж байгаа юм. Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яам руу хүргэдэг тэр бидний дүгнэлт бол буцаад тогтоолын төсөл болж гарах ёстой. Тогтоолын төсөл маань өөрөө манай төсөв дээр тусгах ёстой гэж ойлгож байгаа юм. Тэгэхээр энэний дагуу бол бид болж өгвөл эхний ээлжид бол 0.2-0.3 руу хүрэх чиглэл рүү бид явах ёстой. Бидний гол.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

**С.Эрдэнэболд:** Хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Тэгэхдээ хэдэн зүйл байна.

Нэгдүгээрт нь ер нь энэ бусад улс орнууд, ялангуяа өрсөлдөөнт зах зээлүүдэд шинжлэх ухааны байгууллагууд нь өөрсдөө шууд өрсөлдөх чадварын байгууллагууд болчихдог. Жишээлбэл, сүүлийн үед бол Узбекистан улс цахиурын хөндий рүү гараад тэнд дундад Азийн орнуудын маш том технологийн ХАБ-ыг байгуулаад явж байгаа. Ер нь бол ихэнх орнууд Шанхай ч гэдэг юм уу, Азийн орнууд, дээрээс нь Америк, европын зах зээл дээр ялангуяа шинжлэх ухаан, технологи, өрсөлдөх чадвар гэсэн 3 үг зэрэгцээд явж байгаа. “Science technology and competitive” гээд.

Тэгэхээр манай хууль болохлоор яг Шинжлэх ухаан, технологийн энэ хууль аягүй давжаа хууль. Монголдоо л л байгууллагын дотоод үйл ажиллагааг л зохицуулах гээд байгаа юм шиг боловчиг яг боломж, өрсөлдөх чадвараа тэлсэн, тухайн байгууллага нь санхүү хийгээд төрийн дэмжлэг, мөн зорилгоо хангах, бизнесийн байгууллагуудтай хамтрах, зах зээл дээр бодит боломж, үр дүн, үнэ цэн авчрах, иргэдийн амьдрал, амьжиргаанд эерэг өөрчлөлт авчрах дээр бол асар давжаа байгаад байгаа юм.

Тийм учраас энэ хуулийг ер нь ингээд косметикийн чанартай биш агуулгын чанартай өөрчилж шинэчлэх зайлшгүй шаардлага байгаа юм. Тэр тусмаа дахиад хэлэхэд бол шинжлэх ухаан, технологи “competitive” буюу өрсөлдөх чадвар гэдэг энэ агуулгатай уяхгүй бол өнөөдөр манай улсын жишээлбэл Засгийн газар 578 зүйл, заалттай мөрийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаагийн хэмжих нэгж нь 11 метрикс буюу хэмжих нэгж байгаа. Тийм учраас бол шинжлэх ухаан, төрийн бодлого хоёр нь тийм төсвийн харилцаан дээр л байгаад байгаа болохоос биш яг бодит чадвар дээрээ бол яг энэ бизнесийн боломжуудыг гаргаж ирдэг, энэ нийгмийн шийдвэрүүдийг хошуучилж урд нь явдаг шинжлэх ухааны салбар гэдэгт хэрэгтэй болохоос биш араас нь дагаж явдаг тийм зохион байгуулалттай бүтэц хэрэггүй болчихоод байгаа юм. Уучлаарай Рэгдэл гуай энэ зүгээр би шүүмжилж байгаа юм биш Зөвлөлт маягийн энэ тогтолцоог илүү их тийм чөлөөт нийгмийн өрсөлдөөнд дасан зохицсон маневртай, хурдтай ийм уян хатан “flexible” гэж хэлдэг уян хатан энэ загвар руу оруулах зайлшгүй хэрэгтэй байгаад байгаа. Нэг санаа.

Хоёрдугаарт, энэ аж үйлдвэрийн 3, 4 дүгээр үе рүү, 4 дүгээр үе мэдээлэл технологийн үе, цаашаагаа 5 дугаар үе сансрын технологийн үе гээд явж байгаа. Энэнтэйгээ энэ уялдуулсан байдлаар энэ Шинжлэх ухаан, технологийн хууль энэ боломжуудыг нь гаргаж өгөх хэрэгтэй. Дараагийн санаа үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд улсын төсөв нийцэж байгаа эсэх талаар аудит дүгнэлт гаргах ёстой авч 16 онд батлагдсан Улсын Их Хурлын 48 дугаар тогтоолоор гарсан

энэ зүйл ерөөсөө хэрэгжихгүй байгаад байгаа. Хэмжих нэгж нь тодорхойгүй байгаад байгаа юм.

Уг нь бол улс орны өрсөлдөх чадварын 6 хэмжээсээр Үндэсний аюулгүй байдал үзэл баримтлалаас гаргалаа гэхэд үүнийгээ шинжлэх ухаан, технологитойгоо яаж холбох юм бэ, яаж энэнээсээ илүү их дэмжлэг авах юм бэ гэдгийг бид тооцох ёстой болчхоод байгаа юм. Тийм учраас энэ асуудлыг их тийм цогцоор нь хараад нөгөө муур хар, цагаан байхаас хамаагүй хулгана барьдаг байх ёстой гэдэг шиг шинжлэх ухааны энэ хууль маань өөрөө шинжлэх ухааныг хөгжүүлэхэд чөдөр тушаа болохгүй илүү их давуу тал олгодог ийм зүйл байх ёстой гэж бодож байгаа.

Тэгээд энэ ташрамд бас хэлэхэд энэ жил Нацагдорж гуайн 120 жилийн ой болж байгаа. Шинжлэх ухаан гэдэг үг зүгшрэхээс өмнө анх Судар бичгийн хүрээлэн байгуулагдаж байхад Нацагдорж гуайн өөрийнхөө бүтээлүүд дээр судлах ухаан гэж анх энэ шинжлэх ухааныг томъёолж байсан. Тэгээд шинжилнэ гэдэг бол тийм пассив төрөл, судална гэдэг бол тийм идэвхтэй төрөл байгаа. Тийм учраас яг цаад мөн чанарт нь бас хэдүүлээ энэ хуулийн төслөө уялдуулах тал дээр та бүхнийг анхаараасай гэж хүсэж байна. Тэгээд саяын зүйлүүд дээр байр суурийг сонсьё.

**С.Бямбацогт:** Сархадын Зулпхар гишүүн асуултад хариулъя.

**С.Зулпхар:** Эрдэнэболд гишүүнтэй би бүрэн санал нэгдэж байна. Хуулийн төсөл өргөн барьсан гишүүд маань саяын бид хүрээлэнгүүдээр явж ажиллахаас урьтаж бас тодорхой асуудлыг шийдэх үүднээс хуулийн төсөл оруулж ирсэн. Санаачилсан гэсэн үг. Тэгэхлээр энэ хуулийн төсөл бол тодорхой асуудлын хүрээнд бол бас шийдэл хайж байгаа гэдэг утгаараа бид бас сайшаах ёстой. Сая бид манай дэд хороо болон Байнгын хорооны гишүүд маань хүрээлэнгүүдээр явж ирээд тэр 11 дүгнэлт гаргасан. Санал дүгнэлт. Тэр бол таны хэлсэн зүйлтэй нийцэж байгаа.

Жишээ нь 66 ийм эрдэм шинжилгээний байгууллага байгаа. Хүрээлэнгүүд. Шинжлэх ухааны академийн харьяа 16, яам, агентлагийн харьяа 17, ингээд эрдэм шинжилгээ байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллагын дэргэдэх 20 байгаа юм. Ингээд эрдэм шинжилгээний бусад 10 гээд, хувийн хэвшлийн 3.

Тэгэхээр эдгээр байгууллагууд дээр гол ажиглагдаж байгаа зүйл бол хаана харьяалагдаж байгаагаас шалтгаалаад бас харилцан адилгүй байгаа юм. Жишээ нь МУИС-ийн дэргэд технологийн парк байгуулагдсан. Технологийн паркийн одоо ингээд явж байгаа чиглэл нь зөв стратегитай байгаа юм. Яг таны хэлдэг шиг сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг уялдуулсан ийм холимог загвар руу орчихсон гэсэн үг. Энэ Япон загвар л даа угаасаа. Манайд байж байгаа жишээ нь зарим хэлбэр нь бол яах вэ Зөвлөлт маягийн загвар. Гэхдээ бид энийг шууд үгүйсгэж чадаагүй.

Нөгөөх нь бол Америк маягийн загвар байгаа юм. Тэгэхээр бид ингээд ажиллаад явах ёстой бол бид Америк маягийн загвар руу орчхож чадахгүй юм байна гэдгийг ойлгосон. Тэгэхээр аажуухан орох ёстой загвар бол энэ Дундад

азийн улсууд, Төв азийн улсуудын шилжсэн энэ Япон маягийн загвар юм байгаа юм. Эрдэм шинжилгээний судалгааны байгууллагуудыг энэ их, дээд сургуулиудтайгаа уялдуулсан байдлаар, хувийн хэвшилтэй уялдуулсан байдлаар шинжлэх ухаан, технологийнхоо хөгжлийг эдийн засгийн болон аж үйлдвэрийн үйлдвэр, бусад салбарын хөгжилтэй уялдуулсан ийм схем үйлчилж байгаа юм л даа.

Тэгэхээр энэ рүү бид орохын тулд саяын таны хэлсэн хуулийг бол Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийг бол бүхлээр нь бас ахиад авч үзэх ёстой. Тэгэхээр бид юу ярьж байна гэхлээр зэрэг хамтдаа ахиж хуулийн төсөл санаачилъя гэж байгаа юм. Энэ хуулийн төслийг санаачлахад шинжлэх ухаан манай боловсролын байгууллагын бусад энэ чиглэлээр бол бас эрдмийн зэрэг хамгаалсан улсууд их байгаа шүү дээ. Бид хамтдаа энийг ярилцаж байж хуулийн төсөл оруулж ирэх юм байна гэсэн ийм чиглэлтэй байгаа юм. Энэ дан ганц хаана байхаас нь шалтгаалахгүй. Энэний цаана зохион байгуулалт, энэний цаана тодорхой менежмент, энэний цаана хүний нөөцийн асуудал, хүний нөөцийн хөгжлийн асуудал, санхүүжилтийн жишээ нь тухай хийсэн схемүүд шинээр яригдах юм билээ. Сайн бас жишээнүүд байна. Сайн үр дүнгүүд байна. Тэрийгээ бас цааш нь ашиглах ёстой. Эдийн засаг, хөгжлийн яам бас энэ дээр ажиллаж байгаа. Зохих түвшинд ажиллаад бас эхнээс нь бас тодорхой бас саналууд гарсан байгаа. Энэ талаар бид хамтраад ажиллах юм байна гэдэг ийм ойлголттой байгаа шүү. Та бас энийг бас дэмжээд явж байгаад талархалтай байна. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя. Алга байна. Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

**О.Саранчулуун:** Миний хувьд энэ ажлын хэсэгт орж ажилласан. Ямар шалтгаан байсан бэ гэхлээр шинжлэх ухааны байгууллагуудын статус болон тодорхойлолт, байр сууриудыг нэг мөр цэгцлэхтэй холбоотой саналаа оруулах, ер нь энэ шинжлэх ухааны салбар, их, дээд сургуулийн асуудлуудыг хөндөх зорилгоор ажлын хэсэгт орсон. Тэгэхдээ бид нар өнөөдөр энэ одоо хэлэлцэж байгаа хууль дээр үндсэндээ 2 төрлийн асуудлыг яриад байна.

Нэгдүгээрт, тендерийн үед шаарддаг материалыг болиулах гэдэг босго ярьж байгаа.

Хоёрдугаарт, мэдээллийн сангийн асуудал ярьж байгаа. Бид нар шинжлэх ухаан, технологийн асуудлыг ярихдаа юуг орхигдуулаад байгаа вэ гэхлээр одоо байгаа их, дээд сургуулиудынхаа статус болон байр суурийг бид нар хуулийн нэр томъёонд ер нь цэгцэлж чадахгүй байна. Одоо хүртэл зарим их, дээд сургууль төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэг нэртэй байгаа нэгдүгээр асуудал.

Тэгэхээр хэн өнөөдөр энэ хуулийн болон энэ хуулиас дагалдаж байгаа тэр тендер дээр тавигдах шаардлагаас чөлөөлөгдөх вэ гэдгийг харахлаар одоогийн байдлаар энэ нэр, ангиллаараа хүрээлэнгүүд илүү байна тээ? Энэ нь тэгээд төрийн өмчит болж байгаа гэсэн үг. Тэгэхээр судалгааг зөвхөн төрийн өмчийн байгууллагууд бас хийдэггүй ээ. Олон улсын байгууллагууд хийдэг. Бид нар гэрээгээр олон улсын том том байгууллагууд маш олон бодлогын судалгаа хийдэг, шинжилгээ хийдэг, хөндлөнгийн шинжээч ажлууд хийдэг тээ. Бид нар тэндээс маш их мэдээллүүдийг авдаг хэр нь энэ давуу байдлыг олгож байгаа гэдэг юм уу энэ

зүйлд тэр олон улсын байгууллагын судалгаа болон иргэний нийгмийнхээ судалгаанууд энд орохгүй болчихоод байгаа гэсэн үг.

Тэгэхээр ер нь сүүлийн үед хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүд өөрөө төрийн өмчит хуулийн этгээдэд давуу байдал олгож байгаа нь өөрөө бас илтэд жоохон ашиг сонирхлын зөрчилтэй юм шиг харагдаад байгаа гэж бол би судлаач хүний хувьд хэлж байгаа. Тэгэхээр энэ бол буруу жишиг. Тэгэхээр энийг бид нар өнөөдрийн биш юм гэхэд дараа дараагийн энэ ажлын дэд хэсгээсээ бид нар шинжлэх ухаан, энэ технологийн асуудлыг хөндөж байгаа гишүүдээрээ дахиж хуулийн төслийг үргэлжлүүлэн ярих ёстой. Үргэлжлүүлэн энэ асуудлаа засах ёстой гэдэг байр суурьтай байсан учраас энд ороод яваад байгаа. Тэгэхээр би өнөөдөр энэ зөвхөн ажлын хэсэг гэлтгүй мөн бусад гишүүдээсээ ч гэсэн бас асуумаар байгаа. Ялангуяа ажлын хэсгийн даргаас ер нь цаашдаа бид нар их сургуулийнхаа статусыг ярих.

Дараагийнх нь их, дээд сургуулиа бид нар энэ улс төрөөс салгамаар байна. Их, дээд сургуулиудыг бид нар Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд улс төрийн томилгоо, улс төрийн асуудлууд их орж байгаа учраас энэ нь өөрөө үүсгэн байгуулагчийн төлөөллийг төлөөлөлдөө нөлөөтэй, дээрээс нь хараат бус байдлыг бий болгож дэмжиж өгч чадахгүй байна. Их, дээд сургуулийн удирдлага гэдэг чинь өөрөө их, дээд сургуулийнхаа төлөөлөл байж ингэж сонгогдох ёстой асуудал байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр жишээлбэл бид нар бас л яригдах ёстой л асуудал. Энэ их, дээд сургуулийн асуудал, энэ томилгоо улс төрөөс нөлөөтэй байгаа энэ зүйлүүд болон дараагийн удаа тэр мэдээллийн сангийн асуудлыг иргэний нийгмийн салбар болон олон улсын байгууллагад нээлттэй болгох асуудлаар дараагийн хуулийн төслийг санаачлах уу, энэ дээр ажиллах уу гэдгийг би таны амнаас бас ингэж асуумаар байна. Мөн энэ чуулганы индэрт бас тэмдэглүүлэх зорилготой байгаа учраас бас асууж байгаа шүү. Энийг тан дээр байр сууриа илэрхийлж өгөөч ээ гэж хүсэж байна.

Мөн ажлын хэсгээс бас тодруулъя. Мэдээллийн сан иргэний нийгэм, олон улсын байгууллагуудад яаж нээлттэй байх боломжтой вэ гэдгийг асууя. Би мөн бас санал оруулаад байгаа тэр нь юу вэ гэхээр мэдээлэл байршиж байгаа бол хүртээмжтэй байх ёстой гэдгийг ярьсан.

Хоёрдугаарт, мэдээллийг өмнө нь хийгдсэн судалгаа учраас дахиж хийгдэхгүй гэдэг баталгааг мэдээллийн сан дээр бид нар оруулж чадаагүй. Яагаад гэвэл хуулийн төслийн хүрээнд шинэ заалт оруулж болохгүй гээд байгаа. Тэгэхээр энийг дараагийн шатад яах вэ гэдгийг би ажлын хэсгээс тайлбар авъя.

**С.Бямбацогт:** Ажлын хэсгийн ахлагч Сархадын Зулпхар гишүүн асуултад хариулъя.

**С.Зулпхар:** Би хоёр дахь асуултаас эхлээд хариулъя. Энэ мэдээллийн сангийн асуудал бидэнд яах вэ шинэвтэр зүйл. Байхгүй биш байгаа. Салангид байгааг нь нэгтгэж гаргаж ирж байгаа. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр угаасаа тийм. Бид нөгөө мэдээллийн сан байгуулж байгаа их өгөгдлийг ашиглаж эдийн засаг, нийгэм, улс төрийн бусад шийдвэр гаргана л гэдэг ийм зорилготой

шүү дээ. Энэ үүднээс мэдээллийн сан байгуулж байгаа нь энэ хуулиар бол нэгдсэн сан болж ингэж нээгдэж байгаа юм.

Мэдээллийн санг жишээ нь ажиллуулахтай холбоотой процедурын шинжтэй зохицуулалтууд орсон. Гэхдээ бас зарим зүйл бид нэмж чадаагүй. Энийг Саранчулуун гишүүн сайн мэдэж байгаа. Цаашдаа энэтэй холбоотой асуудлыг бид ингэчихсэн байгаа. Үндэсний судалгааны нэгдсэн мэдээллийн санг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан ажиллуулах гээд. Энэ хүрээндээ энэ зүйлүүдээ шийднэ.

Тэгэхдээ энэтэй холбоотой бидний ярьж байсан тодорхой санал заавал яригдах ёстой. Энийг иргэд, иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллага ашиглах уу гэдэг асуудлыг өөрсдөө зохицуулна гэсэн үг. Ашиглана, ер нь ихэнх мэдээлэл бол нээлттэй байдаг.

Гэхдээ зарим мэдээлэл бол нарийн жишээ нь тооцоолол, судалгаа жишээ нь нууцлалын зэрэгтэй байдаг учраас энийг бол бүрэн нээдэг тохиолдол байна. Хагас нээдэг тохиолдол байна. Бас зарим мэдээллийг бүхэлд нь хаадаг ч тохиолдол байгаа юм. Тэгэхээр энэтэй холбоотой зүйлийг ингээд зохицуулаад явах бүрэн боломжтой гэж ойлгож байгаа юм.

Дараагийн асуудал энэ их, дээд сургуулиудын асуудал ярьж байна. Байнгын хороо болон Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны гишүүд бид хамтдаа бас ажилласан. Их сургуулийн төлөөллүүдтэй бүгдтэй нь уулзсан хамтарсан байдлаар. Их сургуулиуд дээр очиж ажилласан. Энэ явцад юу байсан гэхлээр зэрэг яг таны ярьсан зүйл бас асуудал болж гарч ирсэн. Их сургуулиудыг төрийн өмчит үйлдвэрийн газрын статустай болгочихсон. Энэ бол төсөв, санхүүтэй холбоотой ийм ангилал юм билээ. Тэгэхлээр энэнээс болоод зарим тохиолдолд бол их сургууль өөрийгөө хөгжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргаж чаддаггүй. Энэ төрийн өмчит үйлдвэрийн газрын статустай учраас төсөв, санхүүтэй холбоотой хязгаарлалтууд маш их байдаг.

Тэгэхээр их сургуулийн хувьд тэр нь үндсэндээ хөгжлийг нь боомилсон, хөгжлийг нь хязгаарласан нөхцөлүүд болж байгаа учраас энийг та бүхэн бас цаашдаа авч үзээч ээ гэсэн. Бид мөн адил үүгээр ажиллана гэдгээ бол ажлын хэсэг, Байнгын хороо ажилласан түвшинд бас санал, дүгнэлтээ гаргаад Галбадрах гишүүнээр ахлуулсан манай Улсын Их Хурлаас Улсын Их Хурлын даргын жишээ нь захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг байж байгаа. Тэр нь бол Боловсрол, шинжлэх ухааны жишээ нь чиглэлээр өнөөдрийн нөхцөл байдалд дүгнэлт хийгээд тэгээд санал, дүгнэлт боловсруулж байгаа. Би энийг Галбадрах гишүүнд хүргүүлсэн байгаа.

Тэгэхлээр шинжлэх ухааны чиглэлээр ч гэсэн тодорхой эндээс ямар цаашдаа арга хэмжээ авахтай холбоотой асуудлууд яригдана, саяын их, дээд сургуулиудтай холбоотой зүйл ч гэсэн бас яригдахаар байгаа шүү гэдгийг бас энэ танд мэдээлэл болгоё.

**С.Бямбацогт:** Отгоны Саранчулуун гишүүн тодруулж асууя.

**О.Саранчулуун:** Би ажлын хэсгийг нэмж хариулахыг хүсэж байна. Дараагийн шатад яах вэ гэдгийг үргэлжлүүлээд энэ яриан дээрээ нэгмөсөн баталгаажуулъя гэж бодож байна. Ажлын хэсгээс хариулъя. Тэгээд би хариулахгүй бол бас нэмж хэлье.

**С.Бямбацогт:** 4 дүгээр индэр. Ажлын хэсгийнхэн хариулъя. Сархадын Зулпхар гишүүн.

**С.Зулпхар:** Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Их тодорхой бид 2 зүйл хийх ёстой. Нэгдүгээрт бол шинжлэх ухаан, технологийн чиглэлээр саяын 11 жишээ нь чиглэл гарсан. Энэ хэд болохыг бас ахиад бид хэлэлцэх байх. Тогтоолын төсөл оруулж ирэх нэгдүгээрт шаардлагатай.

Хоёрдугаарт, Шинжлэх ухаан, технологийнхоо хуулийг бид эргэж харах ёстой. Энд бол саяын бидний зохицуулсан хоёрхон зүйлээр хязгаарлагдахгүй бас ийм нөхцөл байдлууд байгаа.

Гуравдугаарт, саяын хэлсэн төрийн их сургуулиудын тухайд шүү дээ. Төрийн өмчит 5 их сургууль байгаа. Энэ их сургуулиудын тухайд саяын статустай холбоотой зүйлийг нь гарцаа байхгүй эргэж харж байж бид нар энэ их, дээд сургуулиудын өөрсдөө бие дааж хөгжих боломжийг олгох юм билээ. Тэгээгүй нөхцөлд гаднаас тухайлбал индомит аваад ирдэг. Индомитоо авахын тулд заавал татвар төлдөг ийм сонин жишээ нь зохицуулалт байж байгаа юм. Тэр нь бүүр 30 хүртэл хувьтай. Гаднын жишээ нь байгууллага санхүүгийн жишээ нь дэмжлэг буюу жишээ нь хандив өгч байхад тэрийгээ жишээ нь бүрэн ашиглаж их, дээд сургуулиудын их дээд сургуулиудын хөгжлийг хангаж чадахгүй ийм байдлууд хүртэл байгаа байхгүй юу. Тэгэхлээр энийг эргэж хар.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Дахиад тодруулж асууя. Отгоны Саранчулуун гишүүн.

**О.Саранчулуун:** Нэмж хэлэхэд энэ 19-ийн штрих 3.1 дээр байгаа эрдэм шинжилгээ, судалгааны ажил хөгжүүлэлт гүйцэтгэгч нь дараах мэдээллийг хуулиар нууцлахыг хориглосноос бусад гээд байгаа. Тэгээд энэ дээр нэгдсэн мэдээллийн санд хүргүүлж, ил тод хүртээмжтэй байлгана гэж байгаа юм. Энэ хүртээмжтэй байлгана гэдэг нь шинжлэх ухааны аливаа тайлан, мэдээлэл нь өөрөө ... өргөтгөлтэй буюу PDF-ээр ч гэсэндээ нөгөө харааны бэрхшээлтэй хүмүүс болон дэлгэц уншигчид ээлтэй хэлбэртэй байрших ёстой гэсэн энэ агуулгаар энэ зүйл, заалтыг оруулсан юм. Энэ формат руу шилжихэд энийг хийхийн тулд журмаар зохицуулагдах юм байна лээ.

Тэгэхээр манай ажлын хэсгийн хувьд энэ дээр нэлээн ярилцаад дараагийн шатад энэ дээр юу дутуу байсан бэ гэхлээр ер нь дахин дахин судалгаа давтагдаад байгааг болиулахын тулд энэ судалгаа өмнө нь хийгдсэн байсан гэдэг лавлагааг авах нэг асуудал энэ зүйлд одоо бид нар тусгаж чадаагүй байхгүй юу. Тэгэхээр энийг нь бас журмаараа заавал тусгах ёстой шүү гэдгийг бас хэлэх гээд байгаа юм.

**С.Бямбацогт:** Үг хэлчихлээ. Санал хэллээ. Дүгэрийн Рэгдэл гишүүн асуултаа асууя.

**Д.Рэгдэл:** Баярлалаа. 2 асуултаа би эхлээд шууд тавьчихъя. Ажлын хэсэг бас бодож байгаарай. Би тэгээд дараа нь яагаад ийм асуулт тавьж байгаа гэдэг талаараа товч тайлбар ярина.

Нэгдүгээрт, энэ хуулийн төсөл маань явж байгаад батлагдчихвал цаашдаа юу хийх ёстой юм бэ? Ямар ямар ажил хийж болох вэ? Өөрөөр хэлбэл, энэ хуулийн төслөөр орж байгаа нэмэлт, өөрчлөлтийг амьдруулахын тулд, ажил болгохын тулд газар дээр нь ажил болгохын тулд ямар алхам хийж болох вэ гэдэг нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуудал бол санхүүжилттэй холбоотой. Эдийн засаг, хөгжлийн яамнаас эрдэм шинжилгээний ажилтны цалинг яаж нэмэгдүүлэх талаараа хийж байгаа тооцоо, судалгаа юу байгаа бол? Ер нь хэд хүртэл нэмэх ийм юм бай байна гэсэн энэ 2 асуулт байна.

Би яагаад ийм энэ санхүүтэй холбоотой юмыг товчхон тайлбарлаад хэлчихье. Хариулахад арай амар байх байлгүй. Өнөөдөр дэлхийн ДНБ-ий 2 хувь шинжлэх ухаан технологийн арга хэмжээнд зарцуулагдаж байгаа. Солонгос 5.3 хувиа, Израил 5 хувийг бол эндээ өгдөг. Ази тив тун удахгүй 2.3 хувиа эрдэм шинжилгээнийхээ ажилд зарцуулдаг болно. Тэгэхээр зэрэг манай улс 5 жилийн үндсэн чиглэлээр 26-аас 30 оны үндсэн чиглэлээр ДНБ-ийхээ 2 хувьд хүргэнэ гэсэн зорилт тавьж байгаа. Энэ бол маш сайн.

Тэрнээс өмнө энэ 27 онд ДНБ-ийхээ 0.36 хувиа шинжлэх ухаандаа өгнө гэсэн. Энэ бас боломжийн зорилго. Ноднин бол ДНБ-ийхээ 0.2 хувь буюу 25 онтой харьцуулахад 2 дахин нэмж оруулсан боловчиг төсөл батлагдахдаа 0.17 болж хасагдаад ингээд явчихсан юм байгаа юм. Тэгэхээр энэ 2, 0.36-даа 27 онд хүргэхийн тулд Сангийн яам болоод бусад ялангуяа энэ Төсвийн байнгын хороо төсвийн ажлын хэсэгтэй их нарийн нягталж, нягтарч ажиллах ёстой.

Хэрвээ бид нар энэ 0.36 хувьдаа 27 онд хүрч чадвал эрдэм шинжилгээний ажилтны цалинг гайгүй нэмж чадна. Одоо шинээр ажилд орж байгаа чадвал эрдэм шинжилгээний ажилтан 1.7 сая төгрөгөөр цалинжиж байгаа гар дээр авч байгаа нь биш 1.7 саяар. Тэгэхээр энэ чинь бол олон улсын жишигтэй харьцуулахад дэндүү харамсмаар, дэндүү бага. Эрдэм шинжилгээний ажилтнууд, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд өөрийнхөө санаачилгаар зарим хүрээлэн дутуу төсвийнхөө зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний нэмэлт орлого олдог. Зарим хүрээлэн академийн хүрээлэнгүүдийг харахад дунджаар 30 хувьтай нь тэнцэхүйц орлогоо олоод үүгээрээ бас сайн ажилтай улсуудынхаа цалинг бага зэрэг нэмдэг ийм боломж байдаг. Тэгэхээр энийг бол албажуулж энэ хувь руу хүргэхгүй бол цаашдаа энэ салбар хөгжиж явна гэхэд хэцүү. Хөрс нэлээн гайгүй хөрстэй би бол тэгж хардаг. Академийн хувьд бид нар ямар ч байсан авлигаас ангид бүс болж чадчихсан явж байгаа. Үнэхээр авлига байхгүй.

Хоёрдугаарт, түрүүн Саранчулуун ч бас хэллээ их сургуультай холбогдуулаад. Бид нар улс төрийн нөлөө, шахаанаас бас ангид явж чадаж байгаа энэ бол чадалтай боловсон хүчнээ дэмжихэд их чухал асуудал юм. Энэ бүхэн хөрс байж байхад одоо бид нар илүү жаахан дэмжлэг өгөх өгвөл илүү хурдтай босож ирнэ. Өрсөлдөх чадвар илт сайжирна. Одоо бид нар Азидаа өрсөлдөх

чадвараараа Азийн 46 улс дотроо 19-өөс 20 дугаар байранд сүүлийн 5 жил тогтвортой байгаад байгаа юм. Цөөхөн хүн амтай гэхэд.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Дүгэрийн Рэгдэл гишүүн асуултаа дуусгаад асуучихъя.

**Д.Рэгдэл:** Хөрс байгаа учраас та бүхэн энэ дээр бас анхааралтай сайн ажиллаарай.

Хоёрдугаарт, энэ салбарын өрсөлдөх чадварыг сайжруулахад нэг чухал хүчин зүйл бол шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа явуулахад саад тотгор учруулж байгаа элдэв эрх зүйн болоод санхүүжилтийн бэрхшээлээс болж чөлөөлөх ёстой юм байгаа юм. Энэ чиглэлээр бид нарын хэдэн гишүүд санаачилга гаргаад ер нь асуудлынхаа хүрээг тодорхойлж авчхаад одоо мэргэжлийн хуульчидтай хамтраад ажиллаж байгаа. Үндсэндээ 20 гаруй хууль дотор өөрчлөлт оруулж байж энэ чөлөөлөх үйл ажиллагаа бас тодорхой хэмжээнд хэрэгжиж болохоор болчихсон байгаа юм.

Тэгэхээр энэнтэй холбогдуулаад бид нар холбогдох яамдаас, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас энэ тэр нэлээн лавлах материалууд авна. Энэ дээр та бүхэн харин нягт авчирч ажиллаж энэ салбарыг энэ чөлөөлөх ажлыг шуурхай болгож өгөөрэй гэж та бүхнээс ингэж хүсэж байна. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Ажлын хэсгийн ахлагч Сархадын Зулпхар гишүүн хариулъя.

**С.Зулпхар:** Рэгдэл гишүүнд баярлалаа. Гарцаа байхгүй үнэн. Одоо манай шинжлэх ухааны ажилтнуудын цалин 1.2-оос 1.7 сая төгрөг байгаа юм. Тэгээд эндээс суутган авахаар зэрэг гар дээр нь хэдий хэмжээний цалин үлдэж байгааг бас ойлгох боломжтой. Багш нарынхаа цалинг нэмсэн нь сайн.

Гэхдээ багш нарынхаа цалингаас бага цалинтай ийм шинжлэх ухааны ажилтнуудтай байгаа юм. Аль ч улсад шинжлэх ухааны салбарт өндөр мэргэшсэн, мэдлэг чадвартай эрдэмтэд, судлаачид байдаг. Цалинг нь зохих түвшинд байлгахгүй бол ингээд салбараа орхиод явчихдаг. Гарцаа байхгүй нөхцөл байдлууд үүсэж байгаа юм. Хүрээлэнгүүдээр яваад үзэхээр ийм зүйл хэлж байгаа шүү дээ. Одоо ингээд ахмад судлаач нар байна. Нэг бол залуу судлаач нар байна гэж. Дунд үеийн судлаач нар хаачсан бэ гэсэн чинь нэг бол гаднын жишээ нь судалгааны байгууллагууд аваад явчихсан. Нэг бол хувийн хэвшил рүү явчихсан. Нэг бол амьжиргаагаа бодоод өөр ажил хийгээд явчихсан гээд ийм байдалтай байгаа юм.

Тэгэхлээр энэ бодит байдал байгаа учраас цалин хөлсний асуудал дээр бас бид гарцаа байхгүй бодлогоор эндээс дэмжихээс гадна саяын чөлөөлье гэдэг бидний зохицуулалтын хүрээнд шинжлэх ухааны хүрээлэнгүүд өөрсдөө судалгаа судалгаа хийгээд нэмэлтээр орлого олж байгаа бол тэрийгээ цалин болон бусад шинжлэх ухааныхаа салбарыг хөгжүүлэх, технологийн хөгжүүлэлт хийхэд нь бол нээлттэй болгох энэ ажлыг бас бид хуулийн хүрээнд хийж өгөх ёстой юм байна лээ гэж байгаа юм. Энэ өөрийнх нь статустай холбоотой бас хязгаарлалтууд байдаг учраас таны хэлж байгаа зүйл үнэн гэж байгаа юм.

Энэнтэй холбоотой бид бас мэдээж хэрэг төсвийн хүрээний мэдэгдэл орж ирнэ. Тэгээд тэрнээс авхуулаад бидний ажиллах юм гарна. Эдийн засаг, хөгжлийн яамтайгаа бид ажиллана. Сангийн яамтай ажиллана. Байнгын хороон дээр бид энэ асуудлуудаа ярина. Нөгөөтээгүүр бол бусад эрдэм шинжилгээний байгууллагуудаасаа бас саналыг нь авсан шигээ тэрийгээ их тодорхой хэлэлцүүлгүүд өрнүүлээд энийг цаашаа явж байж энэ зардлыг нэмэгдүүлэх шаардлага гарах байх гэж бодож байна. Ямартай ч бид судалгааныхаа зардлыг өнөөдрийн байдлаар бол Төсвийн хүрээний мэдэгдлийн эхний байдлаар Шинжлэх ухаан, технологийн сан бол 3.5 дахин нэмэгдүүлээд өгчихсөн тийм ээ. Тэр бол 10 тэрбум байсныг нь 35 тэрбум болгож л өгсөн юм. Бас их даруухан л даа энэ судлаач нар бол. Энэ чиглэлээр бас тал талаасаа ажиллах байх гэж бодож байна.

Хоёр дахь асуудлын тухайд бол энэ хууль батлагдвал юу хийх вэ гэж. Нэгдүгээрт бол бид мэдээж төрийн байгууллагуудтай бол их тодорхой ажиллах ёстой. Ялангуяа төрийн байгууллагууд судалгааны тендерүүд зарладаг бол энийг хүрээлэнгүүдээрээ та бүхэн бас хийлгэх чиглэлд анхаараач ээ гэдгийг ярих ёстой юм байгаа юм. Хүрээлэнгүүд өөрсдөө бас санаачилгатай ажиллах ёстой. Хүрээлэнгүүдийн онцлог бол эрдэмтэн хүн чинь бас заримдаа захиргааны ажлыг бол хийж ерөөсөө чаддаггүй юм шүү дээ онцлог нь тэр. Тэгэхээр энэ чиглэлээр бол бас тодорхой дэмжлэг үзүүлэх ёстой юм байна гэж ойлгож байгаа. Батлагдвал ямар ч байсан эхнээсээ үр дүн гарна. Хувийн хэвшлийн санхүүжилтээр олон улсын байгууллагын санхүүжилтээр хийгдэж байгаа 70-аад тэрбум төгрөгийн судалгаа бол хүрээлэнгүүд авах бас боломж нээгдэнэ ээ л гэсэн ийм ойлголттой байна.

**С.Бямбацогт:** Дүгэрийн Рэгдэл гишүүн тодруулж асууя.

**Д.Рэгдэл:** Тэр би Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуусан энэ эрдэм шинжилгээний ажилтны цалинг нэмэх талаар ямар бодлого, графиктай явж байна вэ гэж. Тэрүүнд хариулт авсангүй нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ерөнхийдөө эрдэм шинжилгээний байгууллагууд худалдан авах ажиллагаанд орох зам бол хуулиараа ингээд батлагдчихвал нээгдэхээр байгаа. Амьдрал дээр юу болдог вэ гэх дээр зэрэг манай энэ янз бүрийн байгууллагууд байна.

Жишээлбэл, Засгийн газрын байгууллагууд, агентлагууд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд энэ тэр гээд нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллага гээд олон газрууд байна. Эд нар бол яг энэ судалгаа, хөгжлийн ажлаа эрдэм шинжилгээний байгууллагаар хийлгэх дургүй. Карманыхаа компаниар хийлгэдэг. Бүүр тийм тохиолдол олон гарч байсан.

Жишээлбэл, Дарханы төмөрлөгийн үйлдвэр гэхэд одоо ган бөмбөлгийн технологи сайжруулах ажлыг барилга засварын компаниар хийлгэж байх жишээтэй. Иймэрхүү.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Мөнхбатын урилгаар Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт хүүхэд багачууддаа Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн

нэрийн өмнөөс ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Бүгдээрээ онц сураарай.

Ажлын хэсэг хариулах уу? Сархадын Зулпхар гишүүн. Тэндээс Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү 4 дүгээр индэр.

**И.Батхүү:** Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Яг улсын төсөв дээр боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх асуудал яригдах үед тухайн үеийн ажлын хэсэг дээр бас манай яамны зүгээс санал гаргаад эрдэм шинжилгээний ажилтнуудынхаа цалинг бас нэмэгдүүлэе ээ гэж хамтад нь оруулаад явсан байгаа. 26 оны 1 сарын 1-нээс эхлээд 15 хувиар нэмэгдүүлэх шийдвэр нь хэрэгжээд эхэлчихсэн байгаа. Үйлдвэрчний эвлэлтэй байгуулсан хамтын хэлэлцээр дээр энэ ондоо багтаагаад 50 хувь хүртэл нэмэгдүүлэх талаар тохиролцсон.

Ер нь цаашдаа 2027 он хүртэл дундаж цалинг 3.5 сая төгрөгт хүргэе ээ гэсэн зорилт тавиад ажиллаж байгаа. Яг өнөөдөр бас үдээс хойш 15 цагаас Үйлдвэрчний эвлэлтэй манай яамныхан уулзаад энэ хэлэлцээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний талаар дэлгэрэнгүй ярилцахаар төлөвлөчхөөд байж байгаа.

**С.Бямбацогт:** Хариулт хангалттай юу? Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

Алга байна. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг дээр гишүүд ажлын хэсэг, Байнгын хорооноос асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно. Үг хэлэх гишүүдийн нэрсийг оруулъя.

Бадарчийн Хэрлэн гишүүн үгээ хэлье.

**Б.Хэрлэн:** Тэр индэр дээрээс хэлэх үү би эндээс хэлэх үү?

Б.Уянга нарын 8 гишүүний өргөн мэдүүлсэн Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах саналыг дэмжиж байна. Тус нэмэлт, өөрчлөлтөөр нэгдүгээрт эрдэм шинжилгээний, судалгааны тайлангийн нэгдсэн санг хөгжүүлж, судалгаа, шинжилгээний бүтээлийг олны хүртээл болгох нөхцөлийг бүрдүүлэх зохицуулалтыг оруулж ирж байна. Энэ бол салбар салбарын эрдэмтэн судлаачдын бүтээсэн мэдлэгийг нэгдсэн сангаас үе үеийн судлаач, үйлдвэрлэгчид түгээх, улмаар мэдлэгийн хуримтлалыг бий болгох нэн таатай боломж бүрдэж байна гэж. Мөн цагаа олсон шийдвэр боллоо гэж үзэж байна.

Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланд дурдсанаар манай эдийн засагт түүхий эдээ боловсруулан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн түвшин сул, голдуу технологийн агууламжгүй бүтээгдэхүүн зонхилж байна гэж дүгнэжээ. Экспортод гарч байгаа бүтээгдэхүүний дийлэнх нь нам технологийн бүтээгдэхүүн байгаа. Дунд болон

өндөр технологи шингээсэн бүтээгдэхүүний хэмжээ дэлхийн дунджаас 7 дахин доогуур байгаа гэж дүгнэсэн байна. Энэ бол шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний судалгааг орхигдуулж ирсний үр дагавар билээ.

Ингэж судалгааны тайлангийн нэгдсэн санг бүрдүүлэхийн зэрэгцээ эрдэм шинжилгээний бүтээлийг үйлдвэрлэл, үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг нэгдсэн байдлаар зохион байгуулах ийм боломжийг энэхүү өөрчлөлт нь оруулж ирж байна гэж үзэж байна. Түүнчлэн судалгааны бүтээлийн патент, оюуны өмчийг баталгаажуулах, тэр тусмаа эрдэмтэн судлаачид оюуны бүтээлийнхээ үр шимийг бодитойгоор хүртэх боломжийг бүрдүүлэх тухайд дараагийн алхмууд хүлээгдэж байгаа билээ. Үүнийг холбогдох байгууллагууд анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Хоёрдугаарт, энэ нэмэлт, өөрчлөлтөөр төрийн байгууллагуудаас зарласан эрдэм шинжилгээ, судалгаа, шинжилгээний аливаа тендерт төрийн өмчийн эрдэм шинжилгээний хүрээлэн, их, дээд сургуулийн судалгааны баг тендерт оролцох бол тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгааны төлбөр, хураамжаас чөлөөлөгдөхөөр зохицуулж байна. Эрдэмтэн, судлаачид, судалгааны байгууллагуудад тулгардаг санхүүгийн томоохон дарамтаас чөлөөлөх энэ санаачилгыг судлаач хүний хувьд дэмжиж байна.

2025 онд шинжлэх, ухаан технологийн салбарын санхүүжилт 105.33 тэрбум төгрөг баталсан байгаа. Энэ зардлын 67.3 хувь нь урсгал зардалд, 5 хувь буюу 5.3 тэрбум төгрөг нь эрдэм шинжилгээний ажлын зардалд зарцуулж байна. Сүүлийн 10-аад жилд эрдэм шинжилгээний ажлын зардалд тогтмол 12 тэрбум орчим төгрөг төлөвлөж, төсөвлөж ирсэн бөгөөд энэ нь огт нэмэгдээгүй бөгөөд 1 судалгаанд дунджаар 14.8-19 сая төгрөгийг зарцуулж ирж байна гэсэн ийм тооцоо байна.

Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагуудын төсөвт тендерт оролцох тохиолдолд төлөх тендерийн хураамж, гүйцэтгэлийн баталгааны хураамжийн төлбөр зардал огт тусдаггүй. Судлаачид энэ зардлыг хувиасаа төлөхөд хүрдэг. Энэ нь шинжлэх ухааны хөгжилд, мөн эрдэмтэн судлаачдын тогтвор суурьшилтай ажиллахад багагүй саад болж байгаа билээ.

НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс гаргадаг дэлхийн мэдлэгийн индексийн үзүүлэлтээр Монгол Улс 2024 онд 47 оноогоор 141 орноос 65 дугаар байрт орсон байгаа. Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас гаргадаг дэлхийн инновацын индексээр Монгол Улс 131 орноос 2023 онд 68 дугаар байрт орсон ийм байдалтай байгаа билээ.

Тэгэхээр мэдлэгийн индекс, инновацын индекс болон шинжлэх ухаан, технологи, инновацын бусад үзүүлэлтээр Монгол Улс дэлхийн дундаж орчимд байгаа энэ цаг үед энэхүү хуулийн төсөлд оруулж ирж байгаа өөрчлөлтүүд нь тодорхой үр дүнгээ өгнө гэдэгт итгэж байна.

Иймд Болдын Уянга нарын 8 гишүүний өргөн барьсан Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа саналыг хэлэлцэхийг дэмжихийг та бүхнээс хүсье.

**С.Бямбацогт:** Бадарчийн Хэрлэн гишүүнд баярлалаа. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн үгээ хэлнэ.

Алга байна. Санал хураалттай холбогдуулж зарчмын зөрүүтэй байр сууриа илэрхийлж, гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалтыг Баасан гаргийн 10 цагт шилжүүлэе. Баасан гаргийн 10 үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан руу санал хураалтыг шилжүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлд хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно гэж урьдчилан зарлаж байна. Дараагийн асуудалдаа оръё.

11 санал хураалт байгаа шүү. Маргааш гишүүд санал хураалтдаа идэвхтэй оролцоорой.

11.23 цаг

### **Гуравдугаар асуудал, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.**

“Газар зүйн нэрсийн жагсаалт батлах тухай” Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн тогтоол байгаа. 2003 оны 42 дугаар тогтоолоор Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт хамаарах 214805 газар зүйн нэр бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн газар зүйн нэрсийн жагсаалтыг баталсан байдаг. Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн зарим нэр Орос, Казак, Тува зэрэг хэл дээр нэрлэгдэж батлагдсан.

Мөн Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт хамаарах зарим газар зүйн нэр үг, үсгийн зөрүүтэй, хэл бичиг, дүрмийн алдаатай байдлаар дээрх тогтоол батлагдсан байх тул газар зүйн нэрийг Монгол хэл дээрх оноосон нэрээр нь өөрчлөн батлуулах, батлагдаагүй орхигдсон болон шинээр тогтоосон газар зүйн нэрийг батлуулахаар уг тогтоолыг нь төсөлд тусгасан байна.

Байнгын хороо нь Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр хуралдаанаар хэлэлцэх эсэхийг нь хэлэлцүүлэг явуулсан. Энэ үеэр бас асуулт асууж, санал гаргасан манай Бат-Эрдэнэ, Бейсен нарын гишүүд гаргасан байна. Тэгээд энэ асуудлыг хэлэлцэнэ ээ одоо.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Баттөмөрийн Энхбаяр танилцуулна.

**Б.Энхбаяр:** Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,

Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах уул, нуруу, гол, нуур зэрэг байгалийн физик газар зүйн объектын нэр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэр, хүний гараар бий болсон объектод оноосон нэрийг Засгийн газар нэгтгэж, Улсын Их Хурлаар батлуулах үүргийг Геодези, зураг зүйн тухай хуулиар хүлээсэн байдаг.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу газар зүйн нэр нь соёлын биет бус өвд хамаардаг бөгөөд Монгол Улсын 2005 онд нэгдэн орсон ЮНЕСКО-ийн 2003 оны соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенц ёсоор газар зүйн нэрийг хамгаалах үүрэгтэй. Мөн Монгол хэлний тухай хуулийн дагуу газар зүйн нэр Монгол хэл дээр батлагдаж ашиглагдах шаардлагатай.

Албан ёсны газар зүйн нэрийг бүх төрлийн газрын зураг дээр тэмдэглэн олон нийтэд таниулахаас гадна улсын хил, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хил, заагийг тогтоох, иргэн үл хөдлөх хөрөнгийн хаягжуулалт зэрэг олон чиглэлээр ашиглаж байна.

Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт хамаарах 214805 нэрийг баталсан бөгөөд үүнээс Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах 8767, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт хамаарах 6941 газар зүйн нэрийг баталсан байна.

Гэвч дээрх газар зүйн нэрийн зарим нь Монгол хэлнээс өөр хэл дээр буюу Орос, Казак, Тува гэх мэт хэл дээр нэрлэгдэж батлагдсан, багийн нэрийг Казак хэл дээр нэрлэж батлуулсан зөрчил илэрсэн тул хээрийн болон суурин судалгаагаар Баян-Өлгий аймгийн 12 сумын нутаг дэвсгэрт хамаарах Монгол хэлнээс өөр хэл дээр баталсан 319 газар зүйн нэрийг тогтоож, мөн 47 газар зүйн уламжлалт нэрийг шинээр тодруулсан байгааг Улсын Их Хурлаар батлуулах шаардлагатай болсон.

Мөн Сүхбаатар аймгийн 13 сумын газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021-2022 онд гүйцэтгэж, батлагдаагүй орхигдсон уламжлалт 2020 газар зүйн нэр болон үг, үсгийн зөрүүтэй, хэл бичгийн дүрмийн алдаатай батлагдсан 45 газар зүйн нэр байгааг тогтоосныг шинэчлэн батлуулах шаардлагатай.

Баян-Өлгий, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт хамаарах тогтоолын төсөлд тусгасан газар зүйн нэрсийг түүхийн эх сурвалж, архивын баримт материал болон орон нутгийн иргэдийн яриа, мэдээлэлд тулгуурлан хээрийн болон суурин судалгааны дагуу тогтоосон бөгөөд газар зүйн албан ёсны нэрийг бүх төрлийн газрын зурагт тэмдэглэж, олон нийтэд зөв нэрээр сурталчлан таниулж, хэрэглээнд нэвтрүүлснээр үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа болсон газар нутаг, байгаль орчныг хамгаалах, хадгалахаас хойч үедээ газар нутгаа хайрлан хамгаалах, үзэл бодол төлөвшлийг өвлүүлэн үлдээхэд чухал ач холбогдолтой.

Иймд Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын газар зүйн нэрийн жагсаалтад дээр дурдсан Баян-Өлгий, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт хамаарах 364 нэрийг өөрчилж, 2067 нэрийг шинээр нэмж батлуулахаар Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусган танилцуулж байна.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Энхбаяр сайдад баярлалаа. Төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**П.Батчимэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын нутаг дэвсгэрт газар нутгийн нэрийг Монгол хэлээр хөтлөн явуулах газар зүйн албан ёсны нэрийн тухай мэдээллээр хангах, хэрэглэх, хамгаалах, газар зүйн нэрийн өөрчлөлтийн бүртгэл хөтлөх зэрэг хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор уг тогтоолын төслийг боловсруулсан байна.

Тогтоолын төсөл батлагдсанаар Баян-Өлгий, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт хамаарах өөрчилсөн шинээр тогтоосон газар зүйн нэрийг газрын зурагт тэмдэглэх, газрын зураг хэвлэх болон мэдээллийн сан бүрдүүлэх ажилд улсын төсвөөс 1.6 тэрбум төгрөгийн зардал гарах бөгөөд тухайн нутаг дэвсгэрт оршин суугчийн газрын эрхтэй холбоотой баримт бичгийн хаягт өөрчлөлт орох үнэ төлбөргүй байхаар зохицуулсан байна.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг D-parliament.mn цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийн байдал, газар зүйн нэр болон хаягжуулалтын асуудлыг хэрхэн зохион байгуулж байгаа талаар, газар зүйн нэрийн өөрчлөлттэй холбогдуулан хил, заагт өөрчлөлт орсон тохиолдолд асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен Баян-Өлгий аймагт эртнээс амьдарч ирсэн Тува иргэдээс газар нутгийн нэр өөрчлөгдөж байгаатай холбогдуулан тогтоолын төсөлд санал авсан эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ газар зүйн нэрийг хамгаалах, хэрэглэх, хяналт тавих талаарх төрийн байгууллагын чиг үүргийг эргэн харах, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен Хаягжуулалтын тухай хуулийн хэрэгжилтийг ханган шаардлагатай бол хуулийг шинэчлэн боловсруулах талаар үг хэлсэн болно.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Пүрэвийн Батчимэг гишүүнд. Баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Баттөмөрийн Энхбаяр Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Дамбын Нямдэлгэр Засгийн газрын ахлах референт, Хэрэг эрхлэх газрын ахлах референт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар Анандын Энхманлай газрын дарга, Далхаагийн Мөнхцэцэг Геодези зураг зүйн хэлтсийн дарга, Хэлний бодлогын үндэсний зөвлөл Нямхүүгийн Нарангэрэл Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албаны дарга, доктор ирсэн байна уу? Ирсэн байна. Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Баянмөнхийн Оюунхорол. Оюунхорол ирсэн байна газрын. Монгол Улсын шинжлэх ухааны академи Цэгмэдийн Цэрэндорж Нийгмийн шинжлэх ухаан хариуцсан Дэд ерөнхийлөгч, шинжлэх ухааны доктор, академич, Очиртогоогийн Шинэбаяр Хэл зохиолын хүрээлэнгийн захирал, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн гишүүн, доктор, Авирмэдийн Дашцэрэн Газарзүй, гео-экологийн хүрээлэнгийн захирал доктор ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Та бүхэнд бас Улсын Их Хурлын тухай хуулийн 21.20-д чуулганы хуралдаанд нэгдсэн мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн гишүүд Улсын Их Хурлын гишүүдийн асууж байгаа асуултад үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх ёстой. Ийм үүрэгтэй шүү гэдгээ сануулъя. Худал мэдээлэл өгөх, санаатайгаар мэдээлэл өгөхөөс зайлсхийж нуун дарагдуулах энэ тохиолдолд бас хариуцлага хүлээдгийг бас сануулъя.

Ингээд Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Алга байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Алга байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

**М.Ганхүлэг:** Газар, усны нэр өөрчлөх гээд байгаа юм шиг хэр хэр нь цаагуураа үндэсний аюулгүй байдалтай холбогдолтой бас их чухал асуудал бас орж ирж байна гэж харж байна. Ялангуяа бас Баян-Өлгий аймаг, Сүхбаатар аймгийн тодорхой бас газрын нэршлүүд бас өөрчлөгдөхөөр байгаа юм байна.

Тэгэхээр ихэвчлэн энэ хил орчмын бүс нутагт бас байгаа нь анхаарал бас нэлээн татаж байна. Энэ бас Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын бас гол энэ асуудал нь хил, хязгаарын халдашгүй дархан байдалд бас шууд нөлөөлөх ийм нөхцөл байдлууд бас цаагуураа бас байж болох юм гэж ингэж бас харж байна. Тэгэхээр ялангуяа энэ Сүхбаатар аймаг, Баян-Өлгий аймаг дээр өөр нэрээр нэрлэгдсэн тодорхой жишээнүүдийг бас хэдүүлээ бас энэ дээр бас жоохон юу ярилцаж ямар өөрчлөлт олгогчоо вэ гэдгийг иргэдэд бас зөвөөр мэдээлэх нь зөв болов уу гэж бодож байна.

Хоёрт нь тухайн бүс нутагт бас ажиллаж байгаа, амьдарч байгаа малчид, иргэдийн бас санал эдгээр төслүүд дээр яаж хэрхэн туссан бэ гэдгийг их чухал.

Олон зуун жилийн туршид бас өөрсдөө нэрлэгдээд ирчихсэн яг цаасан дээр бичигдээгүй ч гэсэндээ нутгийн иргэд бас хоорондоо ярьдаг тэр агуулга, саналуудыг бид нар ер нь хэр тусгасан бэ? Хилээ хамгаална гэдэг зэвсэг барьсан, буу барьсан бас цэрэг эрсээс гадна манай малчдын маань бас ажил байдаг. Тэр утгаараа энэ хил хамгаалах энэ ажилд бас гар бие оролцдог энэ малчдынхаа саналыг бас ер нь хэрхэн тусгасан бэ гэдэг дээр тодорхой бас асуулт асууя.

2023 онд Баян-Өлгий аймаг, Увс аймаг, Ховд аймаг, Дархан-Уул аймаг, Сэлэнгэ, Хэнтий аймгуудад бас тодорхой энэ Их Хурлын 42 дугаар тогтоолоор Монгол хэлнээс өөр байгаа энэ газрын нэршлүүдийг бас өөрчилье гэдэг ийм тогтоол гараад ажиллаж байгаа юм байна. Тэгэхээр бусад аймгуудын мэдээлэл дээр бас ямар байгаа вэ? Энэ бас саналууд бас хэзээ яаж орж ирэх вэ гэдгийг би бас тодотгоод нэмээд асууя.

Сүхбаатар аймгийн хувьд Улсын Их Хурлаар батлуулаагүй 940 байгаа юм байна. Байрлал зөрүүтэй 17, үг, үсгийн буюу энэ хэл найруулга, бичгийн алдаатай 45, газар зүйн бас нэр байгаа юм байна. Ингээд 1080 нэрийг шинээр тогтоож орж ирж байгаа юм байна. Тэгэхээр яг өнөөдөр орж ирж байгаа батлагдаж байгаа байдлаар энэ бүрэн гүйцэд эдгээр агуулгаараа бүгд орж ирж байна гэж үзэх үү, эс үгүй бол ахиад үе шаттай явах уу гэдгийг асууя. Тухайлбал, яг ямар ямар жишээнүүд байна вэ гэдэг дээр бас нэлээн дэлгэрүүлээд иргэдэд бас ойлголт өгөх нь зөв байх.

Жишээ нь гэх юм бол Мөнххаан сум. Сүхбаатар аймгийн Мөнххаан сумд байгаа “Цээлт” нуур гэдгийг “Цээл” нуур гэж нэрлэхээр болж байгаа юм. Ямар үндэслэлээр юм? Энэ дээр яг ямар бас шалгууруудыг тавьж өөрчилдөг юм бэ?

Хоёр дахь нь энэ Сүхбаатар аймгийн Дарьганга сум дээр байгаа “Толгойн дэрс тойром” гэдэг энэхүү газрыг “Толийн дэрс тойром” гэж бүүр агуулгын хувьд бүүр бүтэн өөр агуулгатай болгож байна л даа. Тэгэхээр энэ саналыг ер нь ажлын хэсэг яаж ажиллаж гаргадаг юм бэ гэдгийг бас ойлгуулаад тайлбарлаад өгөх нь зөв байх.

Төсөвтэй холбогдолтой асуудлууд бас байдаг юм байна. Гол төсөв юун дээр явдаг юм бэ? 1.6 орчим тэрбум төгрөг байгаа юм байна. Өөр энэ төсвийг нь задалж байх асууя. Дээр нь энэ “google map”, “maps. me” энэ тэр гээд энэ яг иргэдийн хэрэглээ 3 үгт хаяг гээд эдгээр энэ бас хэрэглээний энэ технологиудтай бас бид нар яаж холбож энийг өөрчлөхөд ямар зардлууд, ямар зохион байгуулалтын ажлууд бас гардаг юм бэ гэдгийг бас тодруулж асууя.

**С.Бямбацогт:** Хэн хариулах вэ? Ажлын хэсэг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга Энхманлай 4 дүгээр микрофон хариулъя.

**А.Энхманлай:** Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар Энхманлай. Улсын хил орчмын бүсэд энэхүү 2 аймгийн газар зүйн нэрийг тодруулах, мэдээллийн сан бүрдүүлэх ажлууд хийгдсэн байгаа. Тэр дундаа бид бүхэн энэ Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэрийг шинээр тогтоож байгаа хэсгүүд бол манай

Монгол Улсын баруун захын томоохон уул, гол, нууруудын нэрс 2003 оны Улсын Их Хурлын тогтоолоор батлагдаагүй үлдсэнийг бид бүхэн бас тогтоож өгч байгаа.

Энд жишээ дурдахад Майнт уул гээд Монгол Улсын хамгийн баруун талын захын цэг байгаа. Энэ баруун талын захын цэгийг энэ 2003 оны 42 дугаар тогтоолд батлаагүй үлдээсэн байгаа. Тийм учраас энийг бид нар батлах нь Монгол Улсын аюулгүй байдал, тусгаар тогтнолын хувьд маш чухал зүйл юм гэж үзэж байгаа. Улсын хилийн асуудал мэдээж 2 улс, хөрш орнуудтай холбоотой. Энэ арай тусдаа шалгалтаар хийгдэж зохион байгуулагддаг. Тийм учраас энэ газар зүйн нэрийн асуудалд хилийн орчмын газар зүйн нэрс дээр аль болох өөрчлөлт оруулахгүй байх ийм гол зарчмыг баримталж байгаа.

Хоёр дахь асуудал болох бүс нутгууд аймгуудын иргэдийн дунд мэдээж бид бүхэн хэлэлцүүлгүүдийг олон удаа зохион байгуулсан. Энэ ажил маань ер нь 2021 оноос хойш хийгдсэн ийм ажлууд байгаа. Тийм учраас энэ олон жилийн хугацаанд бүх сумдын иргэд, мөн сумын засаг захиргааны байгууллагаас томилогдсон төлөөлөгч нар энэ газар зүйн нэр тодруулах ажилд хамтарч ажилласан. Ингээд энэ иргэдийн бас санал дээр үндэслэж энэ газар зүйн нэрийг бас шинэчилж тогтоодог байгаа.

Хэлэлцүүлэг 6 удаа бид бүхэн бас хийсэн байгаа албан ёсоор. Мөн бас байгууллагын цахим хуудас дээр бас тавьж иргэдээсээ санал хүсэлтийг нь авсан. Ингээд энэ 6 аймаг дээр бас онцолж энэ газар зүйн нэрийг Монгол хэлнээс өөр хэл дээр нэрлэж байгааг шалгах ажлыг 2021, 2022 онуудад улсын хэмжээнд явуулсан. Энэ хүрээндээ энэ өнөөдөр оруулж ирж байгаа Баян-Өлгий аймаг дээр 319 нэрийг бид бүхэн зөв болгож Монгол хэл рүү шилжүүлэх энэ Улсын Их Хурлын тогтоолын төсөл орж ирж байгаа. Үүнээс гадна Ховд аймаг, Увс аймаг, Хэнтий аймаг, Дархан-Уул аймаг, Орхон аймаг гэсэн энэ аймгууд дээр энэ газар зүйн нэрийг өөр нэр дээр Монгол хэлнээс өөр нэр дээр ийм баталсан ийм зөрчил гарсан. Тэгээд энэ зөрчлийг дараа дараагийн ээлжид Их Хурал руу оруулж ирж засаж янзлуулна.

Улсын хэмжээнд бусад аймгууд дээр бас энэ газар зүйн нэр тодруулах ажил хийгдэж байгаа. Одоо улсын хэмжээнд 8 аймгийн хэмжээнд энэ ажил бүрэн дууссан байна. Нийслэл Улаанбаатар хотын 9 дүүрэг дээр бас дуусчхаад байна. Тэгэхээр улсын хэмжээний 168 сум дээр энэ газар зүйн нэр тодруулах ажил дуусаж, тогтоол ажлын биелэлт 45.3 хувьтай бид бүхэн 49 аравны.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Асуултаа гүйцээгээд хариулчихъя.

**А.Энхманлай:** 49.3 хувьтай хэрэгжилт нь явж байна. Тэгээд энэ ирэх намрын чуулганаар бид бүхэн энэ бүрэн дууссан аймгуудын газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг бас оруулж ирж хэлэлцүүлнэ ээ. Сүхбаатар аймаг дээр 45 газар зүйн нэрийг Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор алдаатай баталсан байна. Энд бол Монгол хэл бичгийн алдаа, дүрмийн алдаанууд ихэвчлэн гарч ирж байгаа. Мөн бас нутгийн иргэдээс тухайн газар нутгийг зөв нэрлэх ийм бас санал, хүсэлт гарсан. Ийм учраас бид бүхэн энэ 45 нэрийг өөрчилж оруулж ирэх, 2020 нэрийг бас батлаагүй үлдээсэн ийм бас асуудал гарсан учраас энэ нэрсийг шинээр батлуулахаар оруулж ирж байгаа юм.

1.6 тэрбум төгрөгийн зардлын тооцоо судалгаа гарсан. Энд газар зүйн нэрийг шинэ нэрийн дагуу бид бүхэн байр зүйн зургуудыг шинээр бас хэвлэх, мөн самбар, тэмдэг, тэмдэглэгээ байгуулах ийм ажлууд орж ирж байгаа.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн тодруулж асууя.

**М.Ганхүлэг:** Тийм хэл шинжлэх ухааныхан маань бас ямаршуу байдлаар л ажилладаг юм оо ажлын хэсэг дээр? Дүрмийн алдаатай батлаад хэдүүлээ тэгээд л дүрмийнхээ алдааг засаад л ингэ энэ тэр гээд иймэрхүү бас алдаануудыг цаашдаа гаргахгүй байх тал дээрээ, эс үгүй бол энэ Монгол хэлний дүрэм өөрчлөгдсөнтэй холбогдолтой ингээд засаад яваад байдаг юм уу? Энэ дээр тодорхой тайлбар хэлсэн нь зөв байх. Бас өөрийнх нь бас төсвүүд гараад энэ болгоныг бас хийхэд бас зөндөө олон судалгааны ажлууд бас явах ийм бас байдлаар хандахгүйгээр явах нь зөв байх гэж би үзэж байгаа.

Яг цаашдаа нөгөө хэрэглээ аягүй чухал. Яг тэр “google map” бусад тэр аппликэйшнүүд байдаг юм уу, хүмүүсийн иргэдийн тэр хэрэглээнд нэвтрүүлэх энэ чиглэл дээр яаж үндсэндээ харж ажиллах вэ гэдгийг асуусан байх.

**С.Бямбацогт:** 4 дүгээр индэр ажлын хэсэг хариулья.

**А.Энхманлай:** Газар зүйн нэрийн нэр маань өөрөө бас хамгийн гол хэрэглэгдэж байгаа асуудал хаягжуулалтын асуудал яригдаж байгаа. Тийм учраас энэ хаягийг бас зөв оноох, зөв тогтооход энэ газар зүйн нэр хэрэглэгддэг. Тийм учраас бас энэ бид бүхэн энэ газар зүйн нэрийн мэдээллийн санг зөв бүрдүүлснээрээ хаягийн мэдээллийн санд энэ гудамж, зам талбай, газар усны нэрийг зөвөөр бүртгэж, иргэдэд бас энэ газар зүйн нэрээр хаягийг үйлчлэх ийм бас боломж нөхцөлийг бүрдүүлж өгч байгаа юм.

Ер нь хаягийн мэдээллийн систем бас хөгжүүлэх ажил маань бүрэн дууссан. Одоо бол аймгуудын хэмжээнд хэрэглэгдээд явж байгаа. Нийслэл Улаанбаатар хотын гудамж, замууд дээр бас энэ нэр олгох ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлууд бас зохион байгуулж ажиллаж байна. Ингээд цаашид бид нар энэ шинэ хаягийн, шинэ газар зүйн нэрийн дагуу хаягжуулалтын системийг хэрэглээнд гаргаж бас цахим орчинд бас замчлалын системийг аж ахуйн нэгжүүд хөгжүүлж ашиглах ийм боломж бүрдүүлж өгч байгаа юм.

**С.Бямбацогт:** Нэмээд хариулчихъя 4 дүгээр микрофон.

**Н.Нарангэрэл:** 1984 онд Дамдинсүрэн гуай, Осор гуай 2 Монгол хэлний зөв бичих дүрмийг баталсан байдаг. Энэ дүрмийнхээ дагуу л явж байгаа. Монгол хэлний дүрэмд ямар нэгэн өөрчлөлт ороогүй. Бичгийн хэл, аман хэл 2 хоорондоо зөрүүтэй ойлголт. Тийм учраас энэ 2003 оны тогтоол болон өмнө нь газрын нэрийн тодруулалт гарсан. Энэ бичвэрүүд дээр бичгийн хэлээрээ бус, аман хэлээр, үг, үсгийн дүрмийн хувьд болон найруулгын хувьд алдаатай байгаа энэ зүйлийг цэгцлээд явж байгаа.

Монгол хэлний тухай хуульд ямар заалт байгаа вэ гэхээр газар, усны нэрийг Монгол хэлнээс бусад хэлээр орчуулсан, эсвэл бусад хэлний дуудлагаар галиглан бичсэн бол хүнийг 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг

3000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэсэн ийм заалт байгаа. Газар усны нэрийг өөрчил.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Нэмээд хариулчихъя. Хариултаа дуусгая.

**Н.Нарангэрэл:** Тэгэхээр Зөрчлийн тухай хууль дээр байгаа энэ торгуулийн хэмжээг мөнгөн дүнг нь дээш нь тавих ийм шаардлага зүй ёсных байгаа юм.

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ерөнхий боловсролын 12-ын “А” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ сурлагын өндөр амжилтыг, амьдралын аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе.

Ундрам гишүүн маань энд сууж байна. Бүгд харж байгаа байх тийм ээ? Бүгдээрээ онц сурцгаагаарай. Хүссэн мэргэжлээрээ их, дээд сургуульдаа элсээрэй гэж бас ерөөе.

Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

Алга байна. Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

**О.Саранчулуун:** Сайн байцгаана уу? Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3 дээр ийм заалт байдаг юм байна олон улсын баримт бичигт тусгах, газрын зурагт хэрэглэгдэх Монгол Улсын газар зүйн нэр, улсын болон засаг захиргааны нэгжийн хилийн байршил, өөрчлөлтийн талаарх мэдээллийг холбогдох олон улсын байгууллагатай солилцох гэж ийм заалт байна. Энэ заалтын хүрээнд хэн ямар олон улсын байгууллагатай ямар ямар мэдээллийг солилцож солилцож ажилласан юм бэ гэдгийг бас тодруулмаар байна.

Хоёрт нь манай улс ер нь хаягжилтын асуудлыг ямар үе шаттай шийддэг вэ? Иргэн бол засаг захиргааны нэгжээр болон тэдгээр хороо, дүүрэг гээд ингээд хаягаа авдаг, хаалгаа авдаг. Аж ахуйн нэгж байгууллага хаяг авахад ямар процессыг шаарддаг вэ? Тэр хаяг авахтай холбоотой хүртээмжийн асуудлыг ер нь хэн хариуцдаг юм гэдэг асуулт байна.

Дөрөвдүгээр асуулт нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2019 оны 112 дугаар тушаал гэж байгаад байна. Энэ тушаалаар газар зүйн нэрийн зөвлөлийг байгуулж, аймаг, нийслэл, сум, дүүрэгт газар зүйн нэрийн салбар зөвлөл байгуулагдан ажиллаж байна гэдэг ийм бас байдаг юм байна энэ хүчин төгөлдөр баримт бичиг дотор. Нэрийн зөвлөл төрийн бодлогыг хэрэгжүүлдэг, газар зүйн бодлогыг хэрэгжүүлэхдээ үүрэг бүхий орон тооны бус зөвлөл гэнэ ээ. Одоогоор энэ зөвлөлд ер нь ямар ямар хүмүүс байдаг юм, аль аймаг ямар зөвлөлтэй вэ гэдэг дээр бас мэдээлэл авъя. Тэгээд тодруулъя.

**С.Бямбацогт:** Хэн хариулах вэ? Ажлын хэсэг 4 дүгээр индэр хариулъя. Энхманлай дарга.

**А.Энхманлай:** Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйл дээр Засгийн газрын бүрэн эрх дээр заагдсан

байгаа энэ олон улсын байгууллагад тухайн улсын газар зүйн нэрийг бүртгүүлэх, харилцан солилцох ийм ажлууд байдаг.

Тэгэхээр бид Монгол Улсын хувьд НҮБ-ын газар зүйн нэрийн шинжээчдийн бүлэг гэж ийм байгууллага байдаг. Энэ байгууллагатай энэ Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан 214805 нэрийг 2003 онд бүртгүүлж солилцсон байгаа. Ингээд бид бүхэн бас энэ НҮБ-ын бас Статистикийн хороо байдаг. Энэ хороон дээр энэ газар зүйн нэр бол орон зайн дэлхийн суурь өгөгдөл, мэдээлэл гэж бүртгэгдэж явдаг. Тэгэхээр энэ орон зайн мэдээлэлд мөн энэ манай энэ газар зүйн нэр бүртгүүлж ингэж бид бүхэн бас ийм ажлыг хариуцаж явж байна.

Хаягжуулалтын тухайд гэвэл бас түрүүн би хэлсэн газар зүйн нэр маш чухал үүрэгтэй. Тэгэхээр Монгол Улсын хаяг хаягжуулалтын тухай хууль 2013 онд батлагдсан. Тухайн хууль маань өөрөө бас энэ хаягжуулалттай холбоотой харилцааг бас төдийлөн сайн зохицуулж чадаагүй байсан. Тийм учраас энэ 2019 онд энэ хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын журам батлагдаж энэ журам дээр гол асуудал зохицуулагдаж явж байгаа. Тэгээд 2019 оноос хойш Хаягжуулалтын тухай хуулийг шинэчлэн найруулах энэ төслийг бид бүхэн боловсруулаад үзэл баримтлалын төслийг 2 удаа батлуулсан. Удаагүй бас энэ шинэ хуулийн төсөл маань ингээд Их Хуралд орж ирнэ.

Хаягийг олон субъект олгож байгаа юм. Тийм учраас энэ хаягийн давхардал, хийдэл янз бүрийн зөрчлүүд маш их гарч байгаа. Тийм учраас энэ хаягжуулалтын асуудлыг цаашид олон улсын жишгийн дагуу системээр, цахим системээр хүний оролцоогүйгээр хаяг олгодог ийм болгох тал руу нь хуулийн төсөл боловсруулагдсан.

Газрын хаягийг газрын алба олгож байгаа. Барилгын хаягийг барилгын асуудал хариуцсан Хот байгуулалтын газраас.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Нарантуяа-Нара гишүүн чуулганы хуралдааны бас дэгийг баримтлахыг танаас хүсье. Бас чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд бас тодорхой заалтууд байгаа шүү гэдгийг сануулъя. Уншаад өгөх үү. Уншаад өг гэж хүслээ Нарантуяа-Нара гишүүн. Уншаад өгье.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль 15 дугаар зүйл хуралдааны дэг зөрчсөн гишүүнд хүлээлгэх хариуцлага.

15.1.Гишийн хуралдааны дэг зөрчсөн бол дараах хариуцлага хүлээнэ.

15.4.Гишүүн бусдад саад учруулсан, бүдүүлэг үг хэллэг хэрэглэсэн, бусдыг доромжилж, нэр төрийг нь гутаах, гүтгэсэн шинжтэй үг хэлсэн бол хуралдаан даргалагч түүнд урьдчилан сануулахгүйгээр тухайн өдрийн хуралдаанд үг хэлэх эрхийг хасна.

Асуултад хариулж байгаа ажлын хэсгийн гишүүний асуултад хариулахад нь бас нөлөөлж байна.

Отгоны Саранчулуун гишүүн тодруулж асууя.

**О.Саранчулуун:** Хаягжилтынхаа асуудлыг үргэлжлүүлье. Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоол гэж байгаад байгаа юм. Тэн дээр юу байна гэхлээр тогтоолтой холбогдуулаад Монгол Улсын Ерөнхийлөгч 2017 онд Нутаг орны газар зүйн нэрийг хамгаалах тухай 186 дугаар зарлиг гаргаж, тэр нь 2013 оны 10 сарын 31-ний өдрийн 42 дугаар тогтоолоор баталжээ. Энэ тогтоолын хүрээнд энэ газар, усны нэрийг албан хэрэг, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд мөрдүүлэх, тухайн орон нутагтаа ард иргэдийн дунд сэргээн хэвшүүлэх, цаашид хууль бусаар газар орны нэр өөрчлөх гэмт явдалтай хууль тогтоомжийн дагуу тууштай тэмцэхийг бүх шатын Засаг дарга нарт үүрэг болгожээ гэсэн байна. Ямар Засаг дарга энэ хуулийн хэрэгжилттэй холбоотой тайлан, мэдээллүүдийг ирүүлсэн юм бэ? Энэ тайлан, мэдээллийг би бас авахыг хүсэж байна. Энэ дээр бас мэдээлэл өгнө үү.

**С.Бямбацогт:** 4 дүгээр индэр.

**А.Энхманлай:** 2017 оны 7 сарын 10-ны өдрийн 186 дугаар зарлигаар Монгол Улсын Ерөнхийлөгч Газар зүйн нэрийг, газар орны, нутаг орны газар зүйн нэрийг хамгаалах тухай гэсэн ийм зарлиг гаргасан. Энэ зарлигийн хүрээнд бас холбогдох шатны Засаг дарга нарт үүрэг болгосон. Энэ зарлиг хэрэгжүүлэхтэй холбоотой бид бүхэн сая энэ тогтоолууд маань бас ингээд орж ирж байгаа.

Яагаад гэхээр энэ зарлиг дээр хууль бусаар газар орны нэрийг өөрчлөх гэмт явдалтай тэмцэх гэж байгаа юм. Тэгэхээр энэ зарлигийн хүрээнд судалгаанууд хийгдсэн. 6 аймаг дээр ийм зөрчил байна гэдгийг бид тогтоосон байгаа. Мөн зарим аймаг дээр гадаад нэрээр иргэдийн хурлаас баталж, аймгийн иргэдийн хурлаас баталж багийн нэр олгосон ийм зөрчил гарсан. Энэ зөрчилтэй холбогдуулаад холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцсон байгаа. Ер нь энэ Ерөнхийлөгчийн зарлиг гарснаас хойш.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Асуултаа, дуусгачихъя хариултаа.

**А.Энхманлай:** Монгол Улсын Эрүүгийн тухай хууль дээр нэмэлт, өөрчлөлт орсон байгаа 2017 онд. Энэ газар зүйн нэрийг дураараа өөрчилсөн ийм этгээдэд хариуцлага тооцно гэсэн тийм ээ энэ санцын хүрээнд бол хариуцлагыг тооцсон. Зөрчлийн тухай хууль дээр бас нэмэлт энэ газар зүйн нэрийг дур мэдэн өөрчлөхийг бас зогсоосон байгаа.

Ингээд Монгол хэлнээс бид нар өөр хэл дээр байгаа нэрсийг тогтооход 1236 нэрийн тоо гарч ирсэн байгаа юм. Үүнд Казак хэл дээр нэрлэсэн 87, Тува үг 31, Орос үг 19, Хятад үг 5, Төвөд, Түрэг үг 18 гэх мэтчилний ийм судалгаанууд гарсан. Тэгээд энэ цаашдаа бусад аймгууд дээр улсын хэмжээнд энэ судалгааны дагуу илэрсэн зөрчлүүдийг арилгуулахаар бид бүхэн орж ирнэ.

Ер нь яах вэ энэ газар зүйн нэрийн Монгол хэлний хуулийн хэрэгжилт дээр Монополын эсрэг газар хяналт тавих ёстой юм билээ. Мөн манай зүгээс мэдээж хяналт тавьж байгаа орон нутгийн Засаг дарга.../минут дуусав./

**С.Бямбацогт:** Өлзийхүүгийн Шижир гишүүн асуултаа асууя.

**Ө.Шижир:** Өдрийн мэнд. Энэ ер нь маш чухал хууль шүү. Би түрүүн Ганхүлэг гишүүний хэлсэнтэй нь бараг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн

асуулт яригдана гэж 100 хувь санал нэг байгаа. Ер нь зүгээр уул, усны нэрийг батлаад, эсвэл жагсаалтаар Улсын Их Хурлын тогтоол батлаад явж байгаа энэ асуудал ерөөсөө биш. Энэ цаанаа Монгол орны хилийн дархан байдал, мөн баталгаа, үндэсний аюулгүй байдалтай шууд холбогдоно. Ер нь тэгээд бид нар чинь Монголчууд шиг бэлгэдэл ярьдаг, амны бэлгэ ч гэж ярьдаг. Ингээд эртнээс бидэнд өвлөж ирсэн уул, усан дээр өгсөн энэ нэрс яг л тухайн агуулгаа өөрийнхөө оноосон нэртэй ингээд дүйж байдаг л ийм улс шүү дээ. Энэ бас ийм онцлогтой улсууд дэлхий дээр цөөхөн байх.

Монгол Улсын нийслэл уг нь “Өргөө” гэж сайхан нэртэй байлаа. “Номын хүрээ” гэж байлаа. “Нийслэл хүрээ” гэж байлаа. Тэгээд 1924 онд Улаанбаатар гээд ийм коммунист үзэл сурталдсан, үзэл суртлаар өгсөн ийм нэртэй болчихсон. Хажууханд нь Улаан-Үүд гээд Буриадын нийслэл гээд байж байдаг. Үндсэндээ энэ чинь 1921 оны хувьсгалын дараа л коммунист өгсөн коммунист нэр шүү дээ энэ Улаанбаатар гэдэг нэр чинь. Тэгээд ер нь бас нийслэл хотынхоо нэрийг ер нь бараг хуучны нэрээр бас нэрлэвэл яасан юм гэсэн бодол энийг хэлэлцэх үед орж ирлээ.

Цаашлаад зүгээр маш энгийн жишээ хэлье. Зун болохоор Алтай Таван Богд, Сергеаль чиглэлийн аялал гээд л ингээд л аяллын компаниуд бүртгээд эхэлдэг. “Сергеаль” гэдэг нь “Бага түргэний хүрхрээ” Монгол нэрээрээ зөв биз? Тэгээд л Алтай Таван Богд гээд очно. Алтай Таван Богд Монгол нэрээрээ байгаа. Яг тэр “Сергаль” дээр нь очоод “google map” дээр tag хийхээр “Сергаль” гэж гарч гарч ирдэг. Яг бодитой кэйс. Би над дээр тохиолдож байсан жишээ гэсэн үг. Та нар энийг жишээ нь яаж хэрэглээнд нэвтрүүлэх юм? Хамгийн гол юм чинь хэрэглээ шүү дээ. Одоо энэ танилцуулсан материал дээр жишээ нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн хамгийн баруун захын цэг болох “Мааньт” уулын нэрийг одоог хүртэл Улсын Их Хурлаар баталгаажуулан батлуулаагүй учраас ерөнхий боловсролын сургуулийн Газар зүйн хичээлийн сурах бичигт л тэмдэглэл үлдээжээ гэж байгаа байхгүй юу. Энэ бол бас байж болохгүй зүйл шүү дээ.

Цаашлаад бас нэг товчхон асуулт байна. Монгол нэрээр нэрлэгдсэн уул, ус, газар зүйн байршлыг би буруу санаагүй бол хэдхэн жилийн өмнө Баян-Өлгий аймгийн иргэдийн хурал өөр нэрээр нэрлэчихсэн. Бүүр тогтоол батлагдсан байдаг байх аа? Би тэгж санаж байна. Тэгээд иргэдийн хурал нь ингээд өөрсдөө дур мэдээд Монгол нэртэй уул, ус, газар зүйн байршлыг тухайн аймгийнх нь иргэдийн хурал нь батлаад Казак нэртэй болгочихсон. Тэгээд үүн дээр Зөрчлийн хуулиар шийтгүүлээд өнгөрсөн юм шиг байгаа юм. Тэгэхээр Энхбаяр сайд хариулах байх. Энэ тохиолдолд ер нь энэ уул, ус, газар, усны нэрийг зохион байгуулалттайгаар нэрийг нь сольж байна гэдэг энэ чинь бараг үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр цаашид хууль, тогтоолыг нь чангатгах илүү хүнд төрлийн гэмт хэрэг үйлдсэн болоход нөлөөлөх ийм эрх зүйн боломж байгаа юу? Энэ чинь юу гэсэн үг юм хүн Үндсэн хуульд олгогдсон эрхээрээ нэг л удаа нэрээ солих эрхтэй байдаг бол энэ чинь уул, усны, газар нутгийг энэ жишгээр ингээд Монгол нэршлүүдийг нь өөрчлөөд өөрчлөөд иргэдийн хурал нь тогтоол батлаад явдаг болох гээд байна шүү дээ. Тэгээд үүнээс өөр хэдэн тохиолдол байдаг юм? Энэ дээр ер нь хуулийн чангаруулах, зөвхөн Зөрчлийн тухай хуулиар биш Эрүүгийн хуулиар шийдэх ийм боломж байгаа юу гэдэг ийм асуулттай байна.

**С.Бямбацогт:** 4 дүгээр индэр ажлын хэсгийн гишүүн Энхманлай дарга хариулъя.

**А.Энхманлай:** Шижир гишүүний асуултад хариулъя. Ер нь бол энэ газар зүйн нэрд, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн нэрс хамаарагддаг. Тэгээд сая хэллээ. Бас Улаанбаатар хотын нэр, мөн бусад аймгуудын нэр, сумуудын нэр, бүүр багуудын нэрс хүртэл энд хамаарагдаж байгаа. Тэгэхээр иргэдийн хурлаасаа энэ нэрсийг бас баталдаг байгаа. Багийн нэрийг. Тэгээд энэ иргэдийн хурлаас багийн нэр батлахтай холбоотой Баян-Өлгий аймгийн иргэдийн хурлаас энэ Казак нэр дээр багуудынхаа нэрийг батлаад ийм хууль зөрчсөн үйлдэл гаргасан. Энэтэй холбоотой бол бас шалгалт явагдаад ингээд буцааж энэ алдааг зассан. Тэгээд энэ асуудалтай холбогдуулаад холбогдох албан тушаалтнуудад эрүүгийн хэргийн шүүхээс, ЧД-ийн эрүүгийн хэргийн шүүхээр хэлэлцэгдээд ингээд шийтгэл оногдуулсан байгаа.

Ер нь энэ хууль тогтоомжид бас түрүүн хэлсэн Ерөнхийлөгчийн зарлигтай, 17 оны Ерөнхийлөгчийн зарлигтай холбоотой 17 онд нэмэлт, өөрчлөлт гарсан. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хилийн цэсийн нэр, газар орны нэрийг хууль бусаар албан ёсны баримт бичиг, газар зүйн зурагт өөрчилсөн бол 450 нэгжээс 14000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эс үгүй бол 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эс үгүй бол 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ ээ гэсэн ийм Эрүүгийн хуулийн бас зохицуулалт орж ирсэн.

Тэгэхээр бид бүхэн энэ цаашид энэ асуудлыг мөрдүүлж ажиллах хуулийн зохицуулалт ингээд ямар ч байсан орсон байгаад байгаа.

Баян-Өлгий аймгийн иргэдийн аялах, мөн уулын спортын гол бас хэсэг, бүс нутаг болох энэ гол гол уулуудын нэрсийг бас энэ газар зүйн нэрийн тогтоол баталсан нэр дээр гадаад нэрээр, өөр нэрсээр нэрлэсэн байсан.

Тийм учраас бид нар энэ өнөөдрийн энэ тогтоолдоо өөрчлөлт оруулахаар орж ирсэн байгаа. Энд Найрамдал 1, 2 оргил гээд энэ тэр нэрлэчихсэн байсан. Тэгэхээр энд одоогийн нэрлэх ёстой “Бүргэд уул”, “Наран оргил” гэх мэтийн яг тухайн яг орон нутгийн нэрлэх ёстой ийм нэрээр нь шинэчилж батлуулахаар оруулж ирж байгаа.

Ер нь энэ хуулийн хэрэгжилт Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд шинээр батлагдсан тогтоолын дагуу бид бүхэн энэ гол гол хэсгүүд дээр тэмдэгжүүлэлтийн ажлуудыг хийе гэж зорьж байгаа. Энд сая зардлын тооцоонд тусгагдсан энд иргэдэд бас энэ мэдээллийг хүргэх үүднээс чухал чухал газрууд дээр газар зүйн нэрийг нь координатаар нь, координатыг нь бичээд яг ингээд тэмдэгжүүлж бас цаашид хэвшүүлэх, мэдүүлэх энэ ажлыг бид бүхэн орон нутагтайгаа бас хамтарч зохион байгуулахаар төлөвлөж байгаа.

“Сергалийн нуруу” гээд газар байгаа. Тэрийг бид нар “Хотонгийн нуруу” гэж бас өөрчилж орж ирж байгаа.

**С.Бямбацогт:** Сергалийг чинь “Бага түргэн” гэж л хэлдэг, хэлээд байдаг Монголчууд. Одоо ямар нэртэй орж ирж байгаа гэсэн бэ асуултад хариулахдаа

бас тодруулаад. Өлзийхүү Шижирээ гишүүн нэмж асуух уу? Сонсчихъё индрийн 4 дүгээр микрофон.

**А.Энхманлай:** Энэ удаагийн газар зүйн нэрийн тодруулалтын ажил маань мэдээллийн сан бүрдүүлэх гээд ийм ажилтайгаа цуг явагдаж байгаа. Тэгэхээр бүх шинээр тодруулсан болон энэ хуучин 42 дугаар тогтоолоор батлагдсан газар зүйн нэрс маань координаттайгаа, тухайн газрынхаа фото зурагтай, видео бичлэгтэйгээ мэдээллийн сан дээр орж ирж байгаа. Тэгэхээр энэ мэдээллийн сангийн дагуу цаашид бас энэ газар зүйн нэрийг шинээр батлах гэж байгаа, өөрчлөх гэж байгаа, ашиглуулах гэж байгаа, мөн цахим үйлчилгээний бас платформ хөгжүүлж ашиглах гэж байгаа, хаягийг бас олох гэж байгаа ийм газрууд дээрээс газар зүйн нэрийг энэ системээс мэдэж аваад зөв хэрэглэх шаардлагатай болж байгаа юм. Зарим газруудыг би хэллээ тэмдэгжүүлж бас мэдүүлэхгүй бол.

Сергалийн гэдэг дээр энэ 289 дэх хэсэг дээр байна. Цэнгэл сумд байдаг. “Сергаль” тал гэсэн газар “Хотонгийн тал” гэсэн ийм өөрчлөлтөөр орж ирж байгаа. Тува хэл дээр ингээд бичигдсэн гэсэн ийм байсан юм байна.

**С.Бямбацогт:** Цагаанхүүгийн. Мөнхбат гишүүн асуултаа асууя.

Алга байна. Ренчинбазарын Сэддорж гишүүн асуултаа асууя. Ренчинбямбын. Алга байна. Гишүүд асуулт асууж. Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тогтоолын төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ.

Буланы Бейсен гишүүн үгээ хэлье ээ. Индэрт урьж байна таныг. Индэр дээрээс, 2 дугаар индэр дээрээс.

**Б.Бейсен:** Гишүүддээ болон ажлын хэсэгт Улсын Их Хурлын даргадаа өдрийн мэнд хүргэе.

Энэ хуулийн төслийг ерөнхийдөө дэмжиж байгаа юм. Гэхдээ бас анхаармаар асуудлууд байж байна. Энэ зарим юман дээр чинь зориуд өөрчилсөн мэтээр ойлголт өгөөд байх шиг байна. Тэрийг бас зөвөөр тусгах нь зөв байх. Нөгөө талаар бас үндэстэн ястнуудын хооронд яс хаях асуудал бас гарчих вий дээ гэдгээ анхаарна биз.

Нөгөө талаар энэ Цэнгэлийн Тувачууд, Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум энэ тэр чинь Үзэмчингүүд, бусад ястнууд байдаг. Нүүдэлчдийн соёлтой холбоотой хаваржаа, намаржаа, зуслан энэний нэрийг нүүдэлчидтэй холбоотой, соёлтой холбоотой өөрчлөгдсөн байдал байгаа. Энийг бас анхаарч үзмээр. Ялангуяа Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Тувачууд маань Монголын Нууц товчоонд орсон Цэнгэл хайрхан уулаар овоглодог тийм нутаг байгаа. Тийм учраас энэний нэрийг зарим өөрчлөгдсөн байж мэдэх юм.

Энийг бас анхаарна биз. Бас судалгаа авах шаардлагатай. Яагаад гэвэл ахмад маань амьдралын жамаар мөнх бусыг үзээд залуучууд маань мэдэхгүй байж болно. Энийг бас судлах нь зөв, харах нь зөв байх гэж бодож байна.

Жишээлбэл, “Сергаль” гэдэг чинь Казахаар махчилж орчуулбал “Чихний ээмэг” гэдэг утгатай. Тувачуудын юугаар чинь тэр Хотон, Хорго нуур мөс нь хайлаад гулсаад ингээд наашаа Ховд голын эх авдаг. Тэр утгаараа хэлсэн болов уу гэж би ойлгодог. Нөгөөдүүл ч бас тэгж ойлгох байх. Тийм учраас энэ ахмадуудаас бас зарим газар нутгийг зөвөөр нь тусгаад бас санал авах нь зөв байх гэж бодож байна.

Баян-Өлгийн Казахуудын хувьд газар, усны нэрийг санаатайгаар өөрчилсөн юм байхгүй. Тэд нар чинь Монгол улсдаа үнэнчээр зүтгэдэг Монгол Улсын иргэн учраас Монгол Улсынхаа юуг хамгаалалгүй яах вэ. Казакстан гэхэд Чөдөрт, Эмээлт, Монгол гол, Тарвагатай, Наран гол, Тэнгэр уул, Зүүн гарын уул гээд нэр нэршлээрээ байж байдаг. Гэтэл манайх бас хэт махчилж орчуулаад бас тийм яс хаячих вий дээ гэдгийг, буруу ойлголт очих вий дээ гэдгээс бас сэрэмжлэх шаардлагатай.

Манай Урианхайчуудын зуслан гээд хилийн хуучин 12 дугаар баганаас цааш 45км газрыг 61 онд алдсан юм байгаа. Хүрэмт гэдэг уул хүртэл газрыг. Гэтэл энэ мэтийн зарим газар нутгийг өөрчилсөн асуудал дээр бас Монгол улс маань бас үндэсний аюулгүй байдлын үүднээс хандаж байгаа байх. Тэрийг бас дэмжиж байгаа гэдгийг хэлье.

Нөгөө талаар энэ зарим хаягжилтын асуудал байж байгаа. Хаягжилтын хууль. Хэрэгждэггүй ганц хууль бол Хаягжилтын хууль байгаа. Монгол, Казах нэрээр бичдэг асуудал байж байна. Жишээлбэл, Англиар бичсэн Улаанбаатар хотын бүх үйлчилгээний газрууд дээр Англиар байгаа шүү дээ. Тийм учраас энэ асуудал дээр нэгдсэн байр суурьтай хяналт, шалгалтаа хийгээд нэгдсэн шийдвэр гаргавал бас дагалгүй яах вэ. Тэгэхээр энэ асуудал дээр анхаарч ажиллах байх гэсэн саналыг хэлье. Хуулийн төслийг дэмжиж байгаа юм.

**С.Бямбацогт:** Отгоны Саранчулуун гишүүн үгээ хэлье.

**О.Саранчулуун:** Баярлалаа. Энэ зааланд байгаа эрхэм гишүүд болон энэхүү ажлын хэсэгт байгаа бүх хүмүүсийг би 1 удаа асууя. Та бүхэн нүдээ даавуугаар боогоод, чихээ таглаад энэ ордны танхим болон ажилдаа ирж очиж үзсэн үү? 1 өдөр тэгээд оролдоод үзээч ээ гэж хэлэх гээд байгаа юм. Яагаад гэхлээр би яг тэр мэдрэмжийг өдөр болгон авдаг. Үргэлж төөрч, будилж явдаг. Хаана байгаа юм бол, аль хаалгаар орох юм бол, хаана очих вэ гэдэг дандаа асуулт асуудаг 112 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төлөөлөөд энд зогсож байна. Бас энэ хэдэн асуултыг асууж байна.

Лавлаа Дорж гээд хүүхэд байхад ярьдаг байсан. Тэр ямар учиртай вэ гэхлээр ойлгохгүй, эрсдэлтэй алхам хийчих үү гэж айгаад үргэлж асуудаг тээ. Яг тэр шиг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс үргэлж асуудаг. Би жишээлбэл илүү алхахгүйн тулд гэдэг ямба гэхээсээ илүү хаалга нь хаагуураа байх бол, очих газар чинь шатдаа юу, хэдэн километр явах гэдгийг үргэлж асуудаг. Ахмадуудад ч гэсэн энэ асуудал байгаа. Үргэлж л төөрнө, будилна, будилдаг тийм ээ. Ер нь тэгээд

зарим дэлгүүр, хоршоо, нийтийн үйлчилгээ, засаг захиргааны нэгж байгууллагууд олоход төвөгтэй. Үргэлж хаана байх вэ газар орны нэрээс гадна.

Тэгэхээр олоход төвөгтэй, төөрөхөд хэцүү байх тусмаа л энийг бид нар хүртээмжгүй гэж яриад байгаа гэсэн үг. Би сая асуулаа л даа ажлын хэсгээс. 5.2.3 гэдэг энэ хуулийн заалтын чинь хүрээнд олон улсын байгууллагуудтай солилцож энэ хаягжилтын асуудлаар ямар ажил хийсэн юм бэ гэж асуулаа. Хариулт би авч чадсангүй.

Засаг дарга нар 6 аймагт зөрчилтэй асуудал илэрсэн гэж байна. Тэгээд ямар ямар аймаг дээр зөрчил нь гараад юу нь шийдэгдсэн юм бэ гэдгийг асуулаа. Бас тодорхой хариулт авсангүй. Би энэ хариултаа нэмж авахыг хүсэж байна. Цаасаар.

Мөн би асууж байсан ер нь энэ газар зүйн нэр гэдэг асуудал засаг захиргааны нэрээс гадна амьдралын өдөр тутам практик хэрэглээнд ямар ач холбогдолтой вэ? Бид нар газар усны нэрийг буруу нэрлэлээ гээд Эрүүгийн хуулийн хариуцлага хүлээдэг юм байна, ийм хуультай юм байна гэдгийг сая сонслоо. Тэгвэл хаягаа хүртээмжгүй гадаад хэлээр хэлчихсэн, хаагуур орох нь тодорхойгүй энэ учир нь олдохгүй хаалга, үүдтэй байгууллагууд, ийм байшин барьсан аж ахуйн нэгж байгууллагуудад бид нар ямар хуулийн хариуцлага хүлээх юм? Эрүүгийн хариуцлага хүлээх үү? Түүнээс үүдсэн хохирлыг бид нар хэн төлөх юм? Өдөр тутамд бид нар үл хөдлөх хөрөнгийн худалдаачдын зарж байгаа байруудыг харж байгаа. Маш гоё “luxury” үнэтэй, дээд зэрэглэлийн гэж байгаа. Яагаад гэвэл тэд нар тэр эргэн тойрно хүн халтирч унадаг шилэн гялгар плитатайгаа хэвээрээ байгаад байгаа юм? Яагаад хаалга нь нарийхан хэвээрээ байгаад байгаа юм? Яагаад ингээд зөвхөн загвар дээр зөвхөн туранхай хүн өмсдөг хувцас хийдэг шиг яагаад байшин барилга, хот тосгон, бүх газар ингээд хүртээмжгүй байсаар байгаа юм бэ хуультай мөртөө, стандарттай мөртөө „дүрэмтэй мөртөө? Энд өнөөдөр хэн хариуцлага хүлээх юм бэ гэдэг асуултыг би асуумаар байгаа юм.

Хэрвээ бид нар уул, усны нэрээ зөв болгох тухай анхаарч байгаа бол энэ улсад амьдарч байгаа иргэдээ чөлөөтэй зорчих орон зайг нь чөлөөлөөд өг л дөө. Хаягжилт бол хүртээмж учраас би энэ үгийг хэлж байгаа. Би энэ хуулийн энэ төслийг дэмжиж байна.

Гэхдээ энэ дээр үүгээр зөвхөн битгий хязгаарлаач ээ гээд байгаа юм. Зөвхөн орон нутгийн газар, усны нэрийг, хаягийг өөрчлөх тухай бид нар ярихаас гадна өнөөдөр бид нар хүний эрхтэй хаягаа уялдуулах хэрэгтэй байна. Өнөөдөр хүн болгон ухаалаг гар утас хэрэглэж байгаа. “Google map” дээр хаягаа оруулаад явж байгаа. Гэтэл тэн дээр тэр хаяг “google map” дээр хаяг янз бүрийн ойлгомжгүй байгаа шүү дээ. Зарим нь байшингийнхаа нэрээр, зарим тэнд байдаг кофе шопын нэрээр. Тэгээд тэр нь ингээд олон янзаар нэрлэгдсэн. Энэ дээр энэ бүхэл бүтэн хуулийн дагуу байгаа энэ зөвлөл чинь бодлого гаргаж цэгцэлдэггүй юм уу? Энийг би бас тодруулмаар байгаа юм.

**С.Бямбацогт:** Саранчулуун гишүүн бас маш чухал асуудлууд хөндөж байна шүү. Газар, усны нэр өөрчиллөө гээд эрүүгийн хариуцлага хүлээдэг юм байж. Энэ Улаанбаатар хотын гудамж талбай, байшин барилгын хаяг, зөв хаягтай биш буруу

хаягтай байдаг, гадаад, дотоодоор нэрлэчихсэн байдаг. Энэ дээр бас ямархуу цаашид зохицуулалт хийх юм бэ? Мөн бас өөрийнх нь сая хөндөж байгаа асуултдаа хангалттай хариулт авч чадсангүй гэсэн сая хэлсэн асуудлуудаар бичгээр мэдээлэл өгье. Засгийн газраас бичгээр.

Хил, хэл, мал гуравтайгаа байхад хэн бүрэн Монгол бүрэн гэж бас хэлсэн байдаг. Тэгээд өсөхөөс сурсан Монгол хэл мартаж болшгүй соёл, үхтэл орших төрөлх нутаг, салж болшгүй орон гэж бас хэлсэн байдаг. Тийм болохоор бас энэ оноосон нэрийн асуудал, энэ хаягжилтын асуудал маш чухал. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалтай холбоотой асуудал. Энэ дээр бас хэлэлцэх эсэх нь шийдэгдэх гэж байна. Улсын Их Хурлын гишүүд бас онцгой анхаарч ажиллах ёстой шүү. Тийм болохоор Засгийн газраас сая Саранчулуун гишүүний хөндөж байгаа асуудлуудыг хэрхэн яаж шийдэх шийдэл, асуултууд нь дутуу хариулсан мэдээллүүдээ гүйцээж бичгээр өгөхийг бас чиглэл болгож байна.

Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулах ёстой. Санал хураалтыг “баасан” гаргийн үдээс өмнөх чуулган руу шилжүүллээ.

12.15 цаг

### **Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал.**

Дараагийн асуудалдаа оръё. Одоо нэр өөрчлөгдөхгүй байх. Өнгөрсөн 5 дахь өдөр бас танилцуулсан тогтоолын төслийг энэ дээр бас бүлгүүдээс нэмж нэрс ирсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22.1.3-д Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 22.1.1, 22.1.2-т заасны дагуу ирүүлсэн саналыг нэгтгэн нам, эвслийн бүлэгтэй зөвшилцөж Байнгын хорооны бүрэлдэхүүний талаарх саналаа нэгдсэн хуралдаанд танилцуулах гэж заасны дагуу “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол, “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Загджавын Мэндсайхан, Нямтайширын Номтойбаяр, Баттөмөрийн Энхбаяр нарыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Жаргалсайханы Золжаргал, Цагаанхүүгийн Идэрбат, Баатаржавын Мөнхсоёл нарыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Далайн Батбаяр, Батмөнхийн Батцэцэг, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Саруулсайханы Цэнгүүн, Сүхбаатарын Эрдэнэбат нарыг Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны, Цагаанхүүгийн Идэрбат, Чинбатын Номин, Цэндийн Сандаг-Очир, Гончигдоржийн Уянгахишиг,

Лувсанцэрэнгийн Энх-Амгалан нарыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны, Жуковын Алдаржавхлан, Загджавын Мэндсайхан нарыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны, Сайнбуянгийн Амарсайханыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны, Дамбын Батлут, Бадрахын Найдалаа нарыг Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны, Жуковын Алдаржавхлан, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Пүрэвжавын Ганзориг, Бадрахын Найдалаа нарыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос тус тус чөлөөлсүгэй.

2.Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Батын Батбаатар нарыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Далайн Батбаяр, Батмөнхийн Батцэцэг нарыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Цагаанхүү Идэрбатыг Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны, Болдын Жавхлан, Бадрахын Найдалаа. Чинбатын Ундрэм, Баттогтохын Чойжилсүрэн, Баттөмөрийн Энхбаяр нарыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Хассуурийн Ганхуяг, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан нарыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны, Дамбын Батлут, Саруулсайханы Цэнгүүн нарыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны, Пүрэвжавын Ганзориг, Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Жигжидсүрэнгийн Чинбүрэн нарыг Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны, Жаргалсайханы Золжаргал, Загджавын Мэндсайхан, Баатаржавын Мөнхсоёл, Гончигдоржийн Уянгахишиг, Сүхбаатарын Эрдэнэбат нарыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцууллаа. Санал хураалтыг одоо явуулах ёстой. Тогтоолын төслийг батлах санал хураалт явуулах ёстой. Санал хураалтыг “баасан” гаргийн үдээс өмнөх чуулганд шилжүүллээ.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

12.20 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Д.ОТГОНДЭЛГЭР*

